



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ
ЯАМ



GPE Transforming
Education



НҮБ-ын Хүүхдийн Сан

ХҮҮХДИЙН НИЙГЭМ-СЭТГЭЛЗҮЙН АСУУДЛЫН СУДАЛГАА



УЛААНБААТАР
2022



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ
ЯАМ



ХҮҮХДИЙН НИЙГЭМ-СЭТГЭЛЗҮЙН АСУУДЛЫН СУДАЛГАА



УЛААНБААТАР
2022

Энэхүү судалгааг НҮБ-ын Хүүхдийн Сангийн дэмжлэгтэйгээр БШУЯ-ны захиалгаар МУИС-ийн ШУС-ийн Нийгмийн ухааны салбар, Боловсролын хүрээлэнгийн судлаачдын баг гүйцэтгэв.

Судалгааны багийн ахлагч Б.Хишигням, МУИС, БССТ
Д. Бумдарь, МУИС, УТСТ

Судлаачид Н. Должин, МУИС, БССТ
М. Тэгшбуян, Гуанжоу их сургууль, докторант
Б. Болдсүрэн, МУИС, БССТ
С. Санжаабадам, Боловсролын хүрээлэн

Мэдээлэл цуглуулагчид А. Эрхэс, МУИС, БССТ
Ц. Лхагвасүрэн, Боловсролын хүрээлэн
Л. Монголмаа, Боловсролын хүрээлэн
Б. Чүлүүнбилэг, Сэтгэл судлаач
М. Мичидмаа, Сэтгэл судлаач
Э. Анударъяа, Сэтгэл судлаач
Б. Энхмаа, Сэтгэл судлаач
Б. Цэрэнханд, Сэтгэл судлаач
Б. Бадамцэцэг, Сэтгэл судлаач
Б. Түвшинжаргал, Сэтгэл судлаач
Б. Чингүүн, Сэтгэл судлаач
Б. Тэмүүлэн, Сэтгэл судлаач
Г. Энхцацрал, Сэтгэл судлаач
Б. Дөлгөөн, Сэтгэл судлаач
О. Түмэнбуян, Судлаач

Уг судалгаанд дурдсан газарзүйн байршил, сонголт нь НҮБ-ын Хүүхдийн Сангаас аливаа улс орны нутаг дэвсгэр, бүс нутгийн эрх зүйн байдал болон нэр төр, түүний хил хязгаарыг тогтоохтой холбоотой аливаа үзэл бодлыг илэрхийлээгүй болно. Судалгааны агуулга, үр дүн нь НҮБ-ын Хүүхдийн Сангийн үзэл бодол, байр суурийг шууд илэрхийлэх шаардлагагүй болно.

Зохиогчийн эрх: ©2022 Монгол дахь НҮБ-ын Хүүхдийн Сан

АГУУЛГА

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТiv
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	v
ТОВЧИЛСОН ҮГС	vii
НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР	viii
ХУРААНГУЙ	1
УДИРТГАЛ	4
СУДАЛГААНЫ ТОЙМ	5
АРГА ЗҮЙ	7
СУДАЛГААНЫ АРГУУД	7
СУДАЛГААНЫ АРГЫН НАЙДВАРТ ЧАНАР	9
СУДАЛГААНЫ ТҮҮВЭР	9
СУДАЛГААНЫ ХЯЗГААРЛАГДМАЛ БАЙДАЛ	10
СУДАЛГААНЫ ҮР ДҮН	11
ХӨЛ ХОРИОНЫ ҮЕИЙН ГЭР БҮЛ, НАЙЗ НӨХДИЙН ХАРИЛЦАА	11
ХӨЛ ХОРИОНЫ ҮЕ ДЭХ ХҮҮХДИЙН СЭТГЭЛ ХӨДЛӨЛ, МЭДРЭМЖТЭЙ ХОЛБООТОЙ АСУУДЛУУД	16
ХӨЛ ХОРИОНЫ ҮЕИЙН МАЛЧИН ӨРХИЙН ХҮҮХДҮҮДИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ	33
ХӨЛ ХОРИОНЫ ҮЕД ЭЦЭГ ЭХ, БАГШ НАРТ ТУЛГАМДСАН АСУУДАЛ, БЭРХШЭЭЛ	34
ДҮГНЭЛТ	41
ЗӨВЛӨМЖ	44
НОМ ЗҮЙ	46
ХАВСРАЛТ	48

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.	Судалгааны аргууд (хүүхэд)	8
Хүснэгт 2.	Судалгааны аргууд (эцэг эх)	8
Хүснэгт 3.	Судалгааны аргууд (багш)	8
Хүснэгт 4.	Судалгааны түүвэр.	9
Хүснэгт 5.	Судалгааны түүврийн бүтцийн дэлгэрэнгүй	9
Хүснэгт 6.	Сурагчид (хүйс, бүс, анги)	10
Хүснэгт 7.	Бага ангийн сурагчид өөрийн харилцаагаа үнэлсэн байдал	11
Хүснэгт 8.	Хөл хорионы үе дэх гэр бүлийн харилцааны зөрчил маргааныг гэр бүлийн гишүүдийн тоогоор ялган харуулсан байдал	13
Хүснэгт 9.	Хүүхдийн айж байгаа үндсэн асуудлууд (бага, дунд ба ахлах ангиар).	17
Хүснэгт 10.	Стресс, бухимдлын үеийн хариу үйлдлийг хэвийн стандарт үзүүлэлттэй харьцуулсан үр дүн (харгалзах оноогоор).	20
Хүснэгт 11.	Стресс бухимдлын үеийн хариу үйлдлийг харьцуулсан үр дүн (хүйсээр)	21
Хүснэгт 12.	Хүүхдүүдэд илэрч буй стрессийн шинж тэмдгүүд (анги ба хүйсээр)	21
Хүснэгт 13.	Хүүхдийн сэтгэл санааны байдлыг хот, орон нутгаар харьцуулсан үр дүн (эцэг эхийн хариулснаар)	22
Хүснэгт 14.	Гэртээ удаан хугацаагаар байх, хичээлээ хийх нь сурагчдад хүндрэлтэй байгаа эсэх (хүүхдүүдийн хариулснаар)	23
Хүснэгт 15.	Хөл хорионы үеийн сурагчдын бие махбод, зан үйлийн өөрчлөлт (эцэг эхийн хариулснаар)	25
Хүснэгт 16.	Хөл хорионы үеийн сурагчдын хоногийн цахим хэрэглээ (эцэг эхийн хариулснаар)	25
Хүснэгт 17.	Хөл хорионы үеийн хүүхдийн цахим хэрэглээг хот, орон нутгаар харьцуулсан үр дүн (эцэг эхийн хариулснаар)	26
Хүснэгт 18.	Хүүхдийн цагаа зохицуулах байдлыг хот, орон нутгаар харьцуулсан үр дүн (эцэг эхийн хариулснаар)	26
Хүснэгт 19.	Хүүхдүүдийн хичээлээ хийх, амрах цагаа зохицуулсан аргууд.	30
Хүснэгт 20.	Гэртээ хичээллэх нь хүүхдэд хүндрэлтэй байгаа эсэх (хүүхдүүдийн хариулснаар)	30
Хүснэгт 21.	Теле-хичээлийн үед эцэг эхчүүдэд тулгарсан бэрхшээл (эцэг эхчүүдийн хариулснаар)	35
Хүснэгт 22.	Теле хичээлийн үед үүсч байсан бэрхшээлийг хот, орон нутгаар харьцуулсан үр дүн (эцэг эхчүүдийн хариулснаар)	35

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.	Судалгааны аргууд (нэгтгэл)	7
Зураг 2.	Судалгаанд хамрагдсан багш нар (сургуулийн байршлаар)	10
Зураг 3.	Хөл хорионы үеийн харилцааг үнэлсэн байдал (хүүхэд, эцэг эх, багш нарын үнэлгээ).	11
Зураг 4.	Гэр бүлийн харилцаагаа үнэлсэн байдал (дунд, ахлах ангийн сурагчид, хүүхэд ба эцэг эхийн хариулснаар).	12
Зураг 5.	Гэр бүлийн таагүй харилцааны илрэлүүд (зарим нөлөөлөх хүчин зүйлс)	12
Зураг 6.	Дунд, ахлах ангийн сурагчдын найз нөхдийн харилцаа (хөл хорионы өмнө ба хөл хорионы үед)	13
Зураг 7.	Гэр бүлийн харилцааны эерэг өөрчлөлт (багш нарын хариулснаар)	14
Зураг 8.	Гэр бүлийн харилцааны сөрөг өөрчлөлт (багш нарын хариулснаар)	14
Зураг 9.	Найз нөхөд, үе тэнгийнхний харилцаанд гарсан эерэг өөрчлөлт (багш нарын хариулснаар)	15
Зураг 10.	Найз нөхөд, үе тэнгийнхний харилцааны сөрөг өөрчлөлт (багш нарын хариулснаар)	16
Зураг 11.	Хөл хорионы үеийн хүүхдийн сэтгэл хөдлөл, мэдрэмжийн үнэлгээ (хүүхэд, эцэг эхийн хариулснаар)	16
Зураг 12.	Сургууль хаагдсанаас хойших санаа зовнил	17
Зураг 13.	Шинэ хичээлийн жил эхлэхтэй холбоотойгоор сурагчдын сэтгэл зүйн бэлэн байдал (теле-хичээл болон танхимын сургалт).	18
Зураг 14.	Хүүхдийн гэр бүлийнхээ санхүүд санаа зовниж буй байдал	18
Зураг 15.	Дунд болон ахлах ангийн сурагчдын ганцаардал, уйтгар (хүйсээр).	19
Зураг 16.	Хүүхдийн ганцаардлыг харьцуулсан үр дүн (хот ба орон нутаг)	19
Зураг 17.	Хүүхдүүдийн уйтгарлахыг харьцуулсан үр дүн (хот ба орон нутаг).	20
Зураг 18.	Хүүхдүүдийн дасан зохицох чадвар	20
Зураг 19.	Эцэг эхчүүд хүүхдийнхээ хөл хорионы үеийн сэтгэлийн хөдөлгөөний өөрчлөлтийг үнэлсэн байдал	22
Зураг 20.	Хөл хорионы үеийн СӨН-ны хүүхдийн сэтгэл зүйн байдал (эцэг эхийн хариулснаар).	23
Зураг 21.	Хөдөлгөөн багассан гэдгийг харьцуулсан үр дүн (хүйсээр)	24
Зураг 22.	Нэгдүгээр ангиас бусад ангийн сурагчдын цахим хэрэглээ (цагаар).	24
Зураг 23.	Сурагчдад теле-хичээл үзэж байх үед тусалж байсан хүмүүс	27
Зураг 24.	Сурагчдын теле-хичээл үзэж байх үед “Бусдаас хоцрох байх” гэсэн санаа зовнил (хүүхдүүдийн хариулснаар)	27
Зураг 25.	Сурагчдын теле-хичээл үзэж байх үеийн интернеттэй холбоотой санаа зовнил (хүүхдүүдийн хариулснаар)	28

Зураг 26.	Сурагчдын теле-хичээлээ ойлгохгүй, мүү дүн авахаас айх айдас (хүүхдүүдийн хариулснаар)	28
Зураг 27.	Сурагчдын теле-хичээлийн даалгаврын хугацаатай холбоотой сандарч тэвдэх байдал (хүүхдүүдийн хариулснаар)	28
Зураг 28.	Сурагчдын теле-хичээлтэй холбоотой бүхимдлын шалтгаан (хүүхдүүдийн хариулснаар)	29
Зураг 29.	Хүүхдүүдэд гэртээ удаан хугацаагаар байхад тулгарсан бэрхшээл (хүүхдүүдийн хариулснаар)	29
Зураг 30.	Гэртээ хичээллэхэд хүндрэлтэй байхад нөлөөлж буй орчны хүчин зүйл. . .	30
Зураг 31.	Теле-хичээлээ хийсэн тухайгаа үнэлсэн үр дүн (хүүхдүүдийн хариулснаар) .	31
Зураг 32.	Теле хичээлийн үед тулгарсан түгээмэл бэрхшээл (нэгдүгээр ангиас бусад ангийн сурагчдын хариулснаар)	31
Зураг 33.	Сурагчдын тусламж авахыг хүсч байсан хүмүүс (хүүхдүүдийн хариулснаар)	32
Зураг 34.	Эцэг эхчүүдийн хүүхдийнхээ теле-хичээлийн оролцоог үнэлсэн байдал. . .	32
Зураг 35.	Малчин өрхийн хүүхдүүдийн нөхцөл байдал	34
Зураг 36.	Малчин өрхийн хүүхдүүдийн теле-хичээлд гэр бүлийн гишүүд нь тусалсан байдал	35
Зураг 37.	Өрхийн орлого өөрчлөгдсөн шалтгаан	35
Зураг 38.	Өрхийн санхүүгийн өөрчлөлтийг харьцуулсан байдал	35
Зураг 39.	Эцэг эхчүүдийн хүүхдэдээ зарцуулах цаг нэмэгдсэн эсэхийг хот, орон нутгаар харьцуулсан үр дүн (эцэг эхийн хариулснаар).	36
Зураг 40.	Хөл хорионы үе дэх эцэг эхчүүдийн сэтгэл санааны байдал (эцэг эхчүүдийн хариулснаар)	36
Зураг 41.	Багш нарын сэтгэл санааны байдалд гарсан эерэг ба сөрөг өөрчлөлтүүд (багш нарын хариулснаар)	36
Зураг 42.	Дунд ба ахлах ангийн сурагчдын сургууль, багш, хичээлд хандах хандлага (хүүхдүүдийн хариулснаар)	37
Зураг 43.	Эцэг эхчүүдийн хичээлийн шинэ жилийн хүлээлт	39
Зураг 44.	Багш нар хичээлийн зохион байгуулалтын хэлбэрийг үнэлж буй байдал . .	39
Зураг 45.	Судалгааны үр дүнг нэгтгэсэн зураглал.	42

ТОВЧИЛСОН ҮГС

БЗД	Баянзүрх дүүрэг
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БССТ	Боловсрол, сэтгэл судлалын тэнхим
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ДЭМБ	Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
МУИС	Монгол улсын их сургууль
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
НЭЗС	Нийгэм эдийн засгийн статус
ОУБ	Олон улсын байгууллага
СӨН	Сургуулийн өмнөх нас
СХД	Сонгинохайрхан дүүрэг
ТББ	Төрийн бус байгууллага
УТСТ	Улс төр судлалын тэнхим
ШУС	Шинжлэх ухааны сургууль
ЭЕШ	Элсэлтийн ерөнхий шалгалт
ЭМЯ	Эрүүл мэндийн яам

НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

Айдас (Fear) – Аюулаас үүдэлтэй сөрөг сэтгэлийн хөдөлгөөн

Бухимдал (Frustration) – Сэдэл, үйлдэл нь гадаад эсвэл дотоод шалтгаанаар дарагдах үед үүсэх сэтгэл хөдлөлийн хариу үйлдэл

Ганцаардал (Loneliness) – Нийгмийн харилцааны дутагдал, бусадтай харилцах дотно холбоо, хамаарал хангалтгүйгээс үүссэн түгшүүрт мэдрэмж

Дасан зохицол (Adaptation) – Хүн ба гадаад орчны хоорондын тэнцвэрт байдал

Нийгэм-сэтгэлзүй (Psycho-social) – Нийгмийн хүчин зүйлс болон хувь хүний хандлага, бодол санаа, зан үйлийн харилцан хамаарал

Нийгэм-сэтгэл хөдлөл (Socio-emotional) – гэр бүл, найз нөхөд, бүлэг хамт олны харилцаа, үүнтэй холбогдох сэтгэл хөдлөл, сэтгэл хөдлөлөө зохицуулах чадвар

Стресс (Stress) – Сэтгэл зүйн болон биеийн тэнцвэртэй байдал алдагдахад үзүүлэх хариу үйлдэл

Энэгшил (Attachment) – Хоёр хүний хоорондын гүн гүнзгий, тогтвортой сэтгэл хөдлөлийн холбоо

Энэгшлийн түгшүүр (Attachment anxiety) – Ойр дотны хүмүүсийн харилцаанаас шалтгаалцалтай түгшүүр

ХУРААНГУЙ

Монгол улс КОВИД-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор 2020 оны 2 дугаар сарын 3-наас 5 дугаар сарын 31 хүртэл сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг хааж, танхимын сургалтаас зайны сургалт руу шилжсэн. Энэ хугацаанд ерөнхий боловсролын сургууль болон цэцэрлэгийн сургалтыг теле-хичээлийн хэлбэрээр зохион байгуулж, телевизийн сувгуудаар дамжуулсан.

Сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг түр хугацаагаар хааж “хөл хорио” тогтоож, телевизээр тогтсон хуваарийн дагуу теле-хичээл үзэх болсноор удаан хугацаагаар ангийнхантайгаа уулзахгүй байх, хичээлээс гадуурх дугуйлан, секц зэрэг олон хэлбэрийн хөтөлбөрт хамрагдахгүй байх, сургууль олон нийтийн үйл ажиллагаанд оролцохгүй байх нь хүүхэд ганцаардах, ганцаардлаас үүдэлтэй дэлгэцийн хэрэглээ нэмэгдэх, хичээлээ хангалттай сурахгүй байна гэсэн түгшүүр, айдастай болох, сургалтын шинэ хэлбэр болох теле-хичээлийн ачааллаас үүдэн стрессдэх, ээнэгшлийн хэрэгцээ нь хангагдахгүй байх, улмаар суралцах сэдэл нь буурах зэрэг асуудлыг дагуулсан байна. Нөгөө талаас энэ нь хүүхдэд шинээр бий болсон сэтгэл зүйн сөрөг байдал, хандлага үүсэх шалтгаан, үр дагавар болсон.

КОВИД-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх хөл хорио нь хүүхдүүд, тэдний эцэг эх, багшид шинэ туршлага байсан төдийгүй тухайн нөхцөл байдалд дасан зохицож тасралтгүй сургах, суралцах нь бэрхшээл, асуудлыг дагуулсан. Тухайлбал, хүүхдүүд гэр бүлийнхэнтэйгээ үл ойлголцох, хөл хорионы улмаас аав ээж нь ажилгүй болж өрхийн орлого буурч байгаад сэтгэл зовж түгших, эцэг эхчүүд хүүхдийнхээ хичээл, суралцахууд тусалж чадахгүй байгаадаа шаналж зовинох, багш нар хүүхдүүдтэйгээ өдөр бүр амьд харилцаа үүсгэж, сургалтын үйл явцыг бүрэн хянаж, тусалж чадахгүй байгаадаа сэтгэл дундуур байх зэрэг нийтлэг асуудалтай тулгарах болсон байна.

Монгол улс, тэр дундаа боловсролын салбар КОВИД-19 цар тахлын нөхцөл байдлыг дэлхийн бусад улс орнуудын нэгэн адил богино хугацаанд цаг алдалгүй шинжлэн судалж, баримт нотолгоонд суурилсан оновчтой шийдвэр гаргахад онцгойлон анхаарч буй цаг үед НҮБ-ын Хүүхдийн Сан, Боловсрол, шинжлэх ухааны яамны захиалгаар “Хүүхдийн нийгэм-сэтгэл зүйн асуудал, эрсдлийг илрүүлэх судалгаа”-г хийсэн.

Судалгааны хүрээнд сургууль, цэцэрлэгийн танхимын үйл ажиллагааг хаасан, хөл хорио тогтоосон нь хүүхдийн сэтгэл зүйд хэрхэн нөлөөлж байгаа болон хүүхэд, эцэг эх, багшид тулгарч буй асуудал, бэрхшээлийг тодруулан улмаар шинэ хичээлийн жил эхлэхэд сурагчдын нийгэм-сэтгэл зүйн бэлэн байдлыг тодорхойлж, болзошгүй эрсдэлийг бууруулах санал зөвлөмж боловсруулсан.

МУИС-ийн судалгааны судлаачийн ёс зүй, судалгааны дэвшилтэт арга технологийг ашиглан КОВИД-19 цар тахлын хөл хорионы үед хүүхдэд тулгамдаж буй нийгэм-сэтгэл зүй, нийгэм-сэтгэл хөдлөлийн асуудал, эрсдэлийг илрүүлж, үр дагаврыг таамаглах, ялангуяа баримт нотолгоонд суурилсан санал зөвлөмж нь ирээдүйд гарч болох эрсдэлийг урьдчилан тооцох, бэрхшээл асуудал, сөрөг үзэгдлийг даван туулах урьдчилан нөхцөл, бат найдвартай “хана хэрэм” болно гэсэн итгэл үнэмшилтэйгээр энэ удаагийн судалгааг гүйцэтгэсэн.

Судалгааны мэдээллийг тоон судалгааны аргууд болох сэтгэл зүйн тест, шалгах асуулт болон чанарын судалгааны аргууд болох сэтгэл зүйн проектив тест, ярилцлага зэргийг

ашиглан мужилсан санамсаргүй түүврийн аргаар сонгосон түүврээс цуглуулсан. Судалгааны түүвэрт Баянхонгор, Хэнтий аймаг, Улаанбаатар хотын Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчид тэдний эцэг эх, багш нар багтсан. Сургуулийн өмнөх насны хүүхдүүдийн нийгэм-сэтгэл зүйн нөхцөл байдлыг тандах зорилгоор судалгаанд оролцсон, хүүхэд нь цэцэрлэгт явж байсан (цэцэрлэгийг түр хугацаагаар хаахаас өмнө) цөөн эцэг эхээс урьдчилан бэлдсэн асуултын дагуу мэдээлэл цуглуулсан. Анги, хот ба орон нутгаар статистик ач холбогдлын хувьд ялгаатай байдал гарсан тохиолдолд үр дүнг тусгасан болно.

Судалгааг 2020 оны 7-8 дугаар сард зохион байгуулж, судалгааны үр дүн, дүгнэлт, зөвлөмж зэргийг хичээлийн шинэ жилээс өмнө БШУЯ, НҮБ-ын Хүүхдийн Сан болон боловсролын салбарын багш, судлаач, мэргэжилтнүүдэд танилцуулж, хэлэлцүүлэх шахуу хөтөлбөртэй ажилласан.

Судалгааны зарим үр дүнгээс дурдвал, судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 56.2 хувьд дасан зохицох чадвар сул байна. Үүнийг судалгаанд хамрагдсан хүүхдүүдэд аюултай ээнэгшлийн шинжүүд болох зан үйлийн түрэмгий байдал, стресс бухимдал, бусдаас буруу хайх, хэт мэдрэмтгий байдал зэрэг илэрсэнтэй холбон тайлбарлаж байна. Дасан зохицох чадвар нь хүүхдийн харилцаа, сэтгэлийн хөдөлгөөн, зан үйлд сөргөөр нөлөөлж байна. Тухайлбал, аюултай ээнэгшил нь ганцаардал, уйтгар гуниг, харилцааны асуудлуудыг дагуулж байна.

Нийгэм-сэтгэл хөдлөл, хүүхдүүдийн харилцаа, сэтгэлийн хөдөлгөөн, мэдрэмжийг судалж шинжлэх явцад сургууль хаасан хугацаанд гурван сурагч тутмын нэгний гэр бүлийн харилцаа “тааруу”, гурван сурагч тутмын нэгнийх нь найз нөхдийн харилцаа “тааруу” гэсэн үр дүн гарсан.

Хүүхдүүдийн нийгэм-сэтгэл зүйн асуудлын хүрээнд сургуульдаа хандах хандлага, зан үйлийн өөрчлөлтийг шинжлэн үзэхэд сурагчид танхимын хичээлд эерэг хандлагатай, багш болон найз нөхдөө санасан байгаа бол нөгөө талд теле-хичээлээс залхаж халширсан байна. Танхимын хичээлд эерэг хандлагатай байх нөхцөл нь ангийн найз нөхөдтэйгөө уулзах, хамт хичээллэхэд голлож байгаа бол теле-хичээлд сөрөг хандлагатай байхад теле-хичээл хурдан гарч өнгөрдөг, ойлгоогүй зүйлээ асуух боломжгүй, амьд харилцаа байхгүй зэрэг нь голлох шалтгаан болж байна. Мөн хүүхдүүд өөрсдийгөө хөл хорионы үед найз нөхдөөсөө хөндийрсөн, сурлагаар хоцрогдсон гэж үзэж байна. Сургууль түр хаасан, хөл хорио тогтоосон хугацаанд хүүхдүүдийн амьдралын дэглэм өөрчлөгдсөн байна. Тухайлбал, хүүхдүүд хэт орой унтаж хожуу босох болсон, их иддэг болсон, хөдөлгөөний дутагдалд орсон төдийгүй цахим хэрэглээ нь нэмэгдсэн зэргийг дурдаж байна.

Сургуулийн дунд ангийнхан буюу 6-13 насны хүүхдүүдэд стресс бухимдал хэвийн үзүүлэлтээс өндөр бөгөөд сурагчдын дийлэнх нь КОВИД-19 цар тахлаас, сурлагаар хоцрогдохоос айж байгаа тул айдсыг багасгахад дэмжлэг туслалцаа үзүүлэх шаардлагатай байна. Мөн сурлагаар хоцрогдох, КОВИД-19 вирус халдах, өвчлөх, хичээл эхлэхэд шалгалт өгөх, сургууль дээрээ эргэн очихдоо зожиг болсон байх, анги улирахаас айх, санаа зовних зэрэг нь сурагчдын дунд түгээмэл байна.

Судалгааны үр дүнгээс харахад сургууль түр хугацаагаар хаасан, хөл хорио тогтоосон үеийн хүүхдүүдийн харилцаа, сэтгэлийн хөдөлгөөн, зан үйлд гарч буй асуудлууд нь цаашид удаан үргэлжилбэл тэдний бие махбод, танин мэдэхүй, нийгэмшихүй болон бие хүний хөгжилд сөргөөр нөлөөлж болзошгүй байна.

Хүүхдүүдийн дасан зохицох чадвар сул, түүнийг илтгэх гол хүчин зүйл болох харилцаанд бэрхшээл үүсч байгаа нь сэтгэлийн хөдөлгөөн, зан үйлийн асуудлуудыг дагуулж байна. Мөн дасан зохицох чадварт нөлөөлөх эзэнэгшлийн түгшүүр илэрч байна. Эдгээр нь удаан хугацаагаар үргэлжилбэл буруу зан үйлд автах, донтох, бусдын нөлөөнд орох, сурлагаар хоцрох, сурах сэдэлгүй болох, танин мэдэхүйн бэрхшээлүүд үүсэх, сургуулиас завсардах, сургуулиа орхих эрсдэлтэй байгаа тул судлаачдын зүгээс эцэг эх гэр бүл, багш сургууль, салбарын яам болон холбогдох байгууллагууд цаг алдалгүй юу хийх, ямар арга хэмжээ авах талаар санал зөвлөмж боловсруулсан. Эн тэргүүнд хүүхдүүдийн КОВИД-19 цар тахлын айдсыг багасгах зорилгоор мэдээллийг гэр бүлд, сургууль дээр, нийгмийн орчинд хүүхдэд ойлгомжтой байдлаар түгээх, шинэ хичээлийн жил эхлэх үед хүүхдүүдийн хичээлийн агуулгын хоцрогдлыг сэтгэл зүйн дарамтгүйгээр, шалгалтын айдасгүйгээр зохион байгуулах нь нэн чухал байна.

Түүнчлэн хөл хорионоос үүдэлтэй нөхцөл байдал, үр дагавар цаашид гарч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх мэргэжилтэн, багийг сургууль, боловсролын байгууллагуудад ажиллуулахыг зөвлөж байна. Сурагчдад сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх мэргэжилтэн, баг нь их, дээд сургуулийн мэргэжлийн тэнхим, сэтгэл зүйн зөвлөгөө, оношилгооны байгууллагуудтай хамтран ажиллаж эцэг эхчүүд, хүүхдүүд болон гэр бүлийн таатай, зохистой харилцааг дэмжих үйл ажиллагаа зохион байгуулахыг санал болгож байгаа юм.

УДИРТГАЛ

2020 он гарсаар дэлхий дахинаа КОВИД-19 цар тахлын улмаас үүссэн нөхцөл нь хүн ардын амьдралд гэнэтийн, санаанд оромгүй цохилт болохын зэрэгцээ богино хугацаанд нийгэм эдийн засгийн шинэ орчныг бий болгож, хүмүүс хоорондын харилцаанд шинэ дасан зохицохуйг шаардаж байна. Энэ цаг үед боловсролын үйлчилгээний зохистой байдал, оновчтой зохион байгуулалт онцгойлох үүрэгтэй байна. Учир нь цар тахлаас урьдчилан сэргийлэх хөл хорио нь боловсролын бүхий л шатны байгууллагуудын үйл ажиллагааг түр хаахад хүргэж, боловсролын үйлчилгээг танхимын бус зайнаас сургах, суралцах хэлбэрт шилжүүлсэн.

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдөр БНХАУ-ын Ухань хотод шинэ төрлийн вирусийн гаралтай уушгины хатгалгаа өвчин бүртгэгдэж, 2020 оны 3 дугаар сарын 11-ний өдөр ДЭМБ-аас дэлхий нийтийн цар тахлын нөхцөл байдал үүссэнийг зарласан (*WHO, 2020*). 2020 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр Монгол Улсын засгийн газар, ЭМЯ хүн хооронд халдвар бүртгэгдсэнтэй холбоотой хилээ хаасан, 1 дүгээр сарын 27-ны өдрөөс сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг зогсоох тухай шийдвэр гаргаж, 2 дугаар сарын 3-ны өдрөөс Монгол улсын хэмжээнд ерөнхий боловсролын сургуулийн 600,000, цэцэрлэгийн 260,000 гаруй хүүхэд гэрээсээ теле-хичээл үзэж, зайнаас суралцах болсон. Мөн 45,000 гаруй сургууль, цэцэрлэгийн багш хөл хорионы дэглэмд шилжин хүүхдүүдтэй хамтран цахимаар суралцах болсон байна.

Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүд хөл хорионд орж, телевизээр тогтсон хуваарийн дагуу теле-хичээл үзэх болсноор удаан хугацаагаар ангийнхантайгаа уулзахгүй, хичээлээс гадуурх дугуйлан, секц зэрэг олон хэлбэрийн хөтөлбөрт хамрагдахгүй, сургууль олон нийтийн үйл ажиллагаанд оролцохгүй байх нь ганцаардах, ганцаардлаас үүдэлтэй дэлгэцийн хэрэглээг нэмэгдүүлсэн төдийгүй хичээлээ хангалттай сурахгүй байна гэсэн түгшүүр, айдастай болох, сургалтын шинэ хэлбэр болох теле-хичээлийн ачааллаас үүдэн стрессдэх, ээнэгшлийн хэрэгцээ нь хангагдахгүй байх, улмаар суралцах сэдэл нь буурах зэрэг асуудлыг дагуулсан байна. Нөгөө талаас энэ нь хүүхдэд шинээр бий болсон сэтгэл зүйн сөрөг байдал, хандлага, үр дагавар болж байна. Хүнд сэтгэл зүйн сөрөг байдал удаан хугацаагаар үргэлжлэх нь түүний сэтгэцэд нөлөөлөн, нийгмийн эсрэг дайсагнасан зан үйл гаргах магадлалыг нэмэгдүүлдэг (*Brooks, et al., 2020*). Хүүхдийн сэтгэл зүйд сөргөөр нөлөөлж буй нөхцөл байдлыг оруулахгүйгээр зөвхөн суралцахуйн ирээдүйн үнэ цэнийг тооцоолон авч үзвэл дэлхий дахинаа 2020 оны 2-7 дугаар саруудад үргэлжилсэн хөл хорио нь 10 их наяд ам.долларын алдагдалд хүргэж байгаа ажээ (*World Bank, 2020*). Хөл хорионы оргил үед дэлхийн нийт хүүхдийн 90 гаруй хувь нь урт, богино хугацаагаар хөл хорионд орсон (*НҮБ, 2020*) бөгөөд тухайн үеийн бодлого, шийдвэрээс үүсэх нийгэм-сэтгэл зүйн асуудал, эрсдэлийг үндэслэлтэйгээр тооцож амжаагүй байна (*INEE, 2020*).

Тиймээс тухайн цаг үед үүссэн эрсдэлийг эргэн харах, шинжлэн дүгнэх, эрсдэлээс үүдэлтэй сөрөг нөлөөг багасгах, ирээдүйд гарч болзошгүй эрсдэл, сөрөг бүхнээс урьдчилан сэргийлэх, боловсролын үйлчилгээний чухал харилцагчид болох сурагчид, багш нар, эцэг эхийн нийгэм-сэтгэл зүй, нийгэм-сэтгэлийн хөдөлгөөнийг судалж, шаардлагатай сэтгэл зүйн дэмжлэг туслалцаа үзүүлэх нь нэн тулгамдаж байна.

Судалгаа, баримт нотолгоонд суурилсан санал зөвлөмж нь ирээдүйд гарч болох олон эрсдэлийг урьдчилан тооцох, асуудал бэрхшээл, сөрөг үзэгдлийг даван туулах урьдчилан нөхцөл, бат найдвартай “хана хэрэм” болно.

Иймээс судалгааны баг судлаачийн ёс зүй, судалгааны дэвшилтэт арга технологийг ашиглан КОВИД-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор сургууль, цэцэрлэгийн танхимын үйл ажиллагааг түр хааж, хөл хорио тогтоосон хугацаанд хүүхдэд тулгамдаж буй нийгэм-сэтгэл зүй, нийгэм-сэтгэл хөдлөлийн асуудал, эрсдэлийг илрүүлж, үр дагаврыг таамаглах зорилгоор энэ удаагийн судалгааг хийж гүйцэтгэлээ.

СУДАЛГААНЫ ТОЙМ

Дэлхийн улс орнуудад КОВИД-19 цар тахлын насанд хүрэгчид, хүүхэд, өсвөр үе, залуус, гэр бүлд үзүүлж буй нөлөөний талаар цөөнгүй судалгаа хийгдэж байгаа ч бүс нутаг, улс орны онцлог, цар тахлын тархацаас шалтгаалан баримт нотолгоо хязгаарлагдмал хэвээр байна.

Амьсгалын замын хүрц, хүнд хэлбэрийн үрэвслийн шинж тэмдэгтэй халдвар (SARS)-ын тархалтын үед хийсэн судалгаануудаас харахад хөл хорионы нөхцөлд хүүхэд, эцэг эхийн үзүүлэлтийг ердийн нөхцөлтэй харьцуулахад цочролын дараах стрессийн эмгэг (PTSD)-ийн дундаж оноо 4 дахин өндөр байна (Sprang & Silman, 2013). Мөн энэ үеийн хөл хорионы тухай бусад судалгаанд сэтгэл зүйн дараах үр дүнгүүд нийтлэг дурдагдсан байна. Тухайлбал,

- Сэтгэл зүйн сөрөг шинж тэмдгүүд илэрсэн (Mihashi, et al., 2009)
- Сэтгэл хөдлөл нь хэвийн бус болсон (Yoon, Kim, Ko, & Lee, 2016)
- Сэтгэл гутрал/депрессийн түвшин нэмэгдсэн (Hawryluck, et al., 2004)
- Стрессийн түвшин нэмэгдсэн (DiGiovanni, Conley, Chiu, & Zaborski, 2004)
- Сэтгэл санаагаар унаж урам зориг буурсан, амархан бүхимддаг болсон, нойргүйдсэн (Lee, Chan, Chau, Kwok, & Kleinman, 2005)
- Цочролын дараах стрессийн эмгэг өндөр илэрсэн (Reynolds, et al., 2008)
- Үүр бүхимдалтай болсон (Marjanovic, Greenglass, & Coffey, 2007)
- Сэтгэлийн тэнхээ барагдсан (Maunder, Hunter, & Vincent, 2003) зэргийг дурдаж байна.

КОВИД-19 цар тахлын үеийн хүүхдийн нийгэм-сэтгэл зүйн чиглэлээр Англи, Итали, Испани улсуудад судалгаа хийсэн байна. Тухайлбал, хөл хорионы эхэн үед Их Британид хийсэн судалгааны үр дүнгээс харахад, хөл хорионоос үүдэлтэйгээр хүүхдийн сэтгэл зүйд уйдах, гэр бүл, найз нөхдөө санаж ганцаардах шинж тэмдгүүд илэрч, нийгэм-сэтгэл хөдлөлийн хөгжил удааширсан байна (Fegert, Vitiello, Plener, & Clemens, 2020; Saurabh & Ranjan, 2020; Clerici, Massimino, & Ferrari, 2020).

Испани улсад цар тахлын эхэн үед хүүхдийг 4 долоо хоног хөл хорионд байлгахад бие махбод болон сэтгэцийн эрүүл мэндэд үүсэх эрсдэл маш өндөр байгааг онцолжээ (Grechyna, 2020). Цаашлаад хүүхэд ямар нэгэн байдлаар хөгжлийн тусгай хэрэгцээтэй, НЭЗС доогуур бол хөл хорионоос үүдэлтэй сөрөг үр нөлөөнд илүүтэй өртөж байна (Jæger & Blaabæk, 2020; Andrew, et al., 2020; Bol, 2020; Darlington, et al., 2020).

Монгол улсын тухайд 2020 оны 4 дүгээр сард Нээлттэй Нийгэм Форум, Хөгжлийн Бэрхшээлтэй Хүүхэдтэй Эцэг Эхчүүдийн Холбоо хамтран хөл хорионы нөхцөл байдал хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй өрхүүдэд хэрхэн нөлөөлж байгааг судалж үр дүнг олон нийтэд танилцуулсан. Уг судалгаанд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй 85 эцэг эх, асран хамгаалагчийн 66-д хөл хорионы нөхцөлтэй холбоотойгоор ямар нэгэн байдлаар сэтгэцийн эрүүл мэндийн асуудал үүссэн байна. Эдгээр асуудлууд нь өрхийн орлого болон эцэг эхчүүдийн хүүхдийнхээ эрүүл мэнд, сэтгэл санааны байдалд зовних нөхцөл байдалтай холбоотой байна. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд сэтгэл санаа, бие физиологи

хямрах (16), сэтгэцийн эрүүл мэндийн асуудал үүссэнээс эмчид хандах (3), байнга уурлаж бухимдах (7), агаар дутагдах, нойргүйдэх (2), өдрийн дэглэм алдагдах (1) зэрэг асуудал илэрч байгааг дурджээ (*Нээлттэй Нийгэм Форум, 2020*).

КОВИД-19-ийн учруулж буй нөлөөллийн талаарх судалгаанаас үзвэл, аймгийн төв, сумдад оршин суудаг гэр бүлүүд хүүхдүүдээ хөдөө амьдардаг хамаатан садных руугаа явуулсны улмаас хүүхдүүд сэтгэлээр унах, зарим тохиолдолд бие махбодын хүчирхийлэлд өртөх явдал гарч байна. Түүнчлэн хүүхдүүдийн зан байдалд сөрөг өөрчлөлт орсон, үйдаж, сургууль, найз нөхдөө санаж байгаа төдийгүй эцэг эхчүүдээс хүмүүжлийн сөрөг арга хэрэглэж байна гэжээ (*Дэлхийн Зөн Монгол ОУБ, 2020 оны 5 дугаар сар*).

7 дугаар сард НҮБ-ын Хүүхдийн Сангийн судалгаагаар хүүхдүүдийн сэтгэл санааны байдал “маш муу”, сэтгэл зүйн асран хамгаалалт “сул” гэсэн үр дүн гарчээ. Цаашлаад 10 эцэг эх тутмын 1 нь хүүхдээ сэтгэл хөдлөл, нийгмийн харилцаа, зан үйлийн бэрхшээлтэй гэж үзсэн. Мөн сэтгэл зүйн асран хамгаалалтын хувьд хүйсийн ялгаа илэрсэн, эрэгтэй хүүхдүүдэд үзүүлэх сэтгэл зүйн асран хамгаалалт бага, хүүхдийн нийгэм-сэтгэл зүйн сайн сайхан байдалд анхаарах эцэг эхийн мэдлэг ойлголт “сул” байна гэжээ (*НҮБ-ын Хүүхдийн Сан, 2020*).

АРГА ЗҮЙ

Боловсролын байгууллагуудыг түр хаасан, хөл хорио тогтоосонтой холбоотойгоор хүүхдийн нийгэм-сэтгэл зүйн нөхцөл байдлыг тодорхойлох зорилгын хүрээнд дараах зорилтуудыг тавьж ажиллав. Үүнд:


- Хүүхэд, эцэг эх, багш нарт тулгамдах нийгэм-сэтгэл зүй, нийгэм-сэтгэл хөдлөлийн эрсдэлийг илрүүлж, түүний үр дагаврыг таамаглах
- Хүүхдийн сэтгэл зүйд гарч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зөвлөмжийг боловсруулах

СУДАЛГААНЫ АРГУУД

Судалгаанд тоон болон чанарын судалгааны дараах аргуудыг ашигласан. Тухайлбал:

- Тоон судалгааны арга: сэтгэл зүйн тест, шалгах асуулт
- Чанарын судалгааны арга: сэтгэл зүйн проектив тест, ярилцлагын арга

ЗУРАГ 1. СУДАЛГААНЫ АРГУУД (НЭГТГЭЛ)



ХҮСНЭГТ 1. СУДАЛГААНЫ АРГУУД (ХҮҮХЭД)

Илрүүлэх үзүүлэлт	Аргын тухай	Харилцаа	Хандлага	Амьдралын хэвшил, зуршил	Сэтгэл хөдлөл
Шалгах хуудас	Сургууль хаасантай холбоотойгоор хүүхдийн сэтгэл хөдлөл, бие махбодь, дадал зуршил, харилцаанд гарсан өөрчлөлтүүдийг илрүүлэх асуулга	✓		✓	✓
Ярилцлага	Сургууль хаасны дараах хүүхдийн найз нөхөд, гэр бүлийн харилцааны онцлог, теле-хичээлийн тохиромжтой байдал, 9 дүгээр сард хичээл үргэлжлэхтэй холбоотой хүлээлтийг тодруулах асуултууд	✓		✓	✓
Дуусгаагүй өгүүлбэрийн арга	Дуусгаагүй өгүүлбэрийн аргын Л.Сакс, В.Леви нарын боловсруулсан хувилбарт тулгуурлан тус судалгаанд зориулан боловсруулсан сургууль, багш, теле-хичээлд хандах хандлага, хичээлийн хүлээлтийг тодорхойлох бодомжууд бүхий проектив арга	✓	✓		✓
Нөхцөл байдлыг сэргээн сануулах	Судалгаанд хамрагдсан сурагчдын теле-хичээл үзэж байх үе дэх сэтгэл зүйн онцлогийг илрүүлэхийн тулд тухайн үеийн нөхцөл байдлыг эргэн сануулах сэтгэл зүйн арга-техникийг (e-prime) ашиглалаа. Энэхүү арга-техник нь тухайн нөхцөл байдлыг ухамсартайгаар болон ухамсаргүйгээр гэсэн 2 байдлаар сэргээн сануулдаг. Бид судалгаандаа ухамсаргүйгээр сэргээн сануулах (conceptual priming) аргыг сонгож ашигласан.				✓
Рене Жилиягийн проектив арга	Хүүхдийн гэр бүл, найз нөхөдтэйгөө харилцах харилцааг судлах проектив тестийн арга	✓			
Гэр бүлийн харилцааг үнэлэх асуумж (FAD)	Гэр бүлийн харилцааг үнэлэх өөрийн үнэлгээний арга		✓		
Розенцвейн проектив тест	Түгшүүр, стресс, бухимдал, түрэмгий байдлыг илрүүлэх сэтгэл зүйн проектив тест. 6-12 насны хүүхдэд хүүхдийн хувилбар, 13-18 насны хүүхдэд насанд хүрэгчдийн хувилбарыг сонгон ашигласан.				✓

ХҮСНЭГТ 2. СУДАЛГААНЫ АРГУУД (ЭЦЭГ ЭХ)

Илрүүлэх үзүүлэлт	Шалгах хуудас	Ярилцлага	Гэр бүлийн харилцааг үнэлэх асуумж (FAD)
Харилцаа		✓	✓
Хүүхдийн зан үйл, сэтгэл хөдлөлийн өөрчлөлт	✓	✓	

ХҮСНЭГТ 3. СУДАЛГААНЫ АРГУУД (БАГШ)

Илрүүлэх үзүүлэлт	Асуулга
Сурагчдын нийгэм, сэтгэл зүйн асуудал, эрсдэл	✓
Сурагчдын нийгэмшил, харилцаа	✓
Сурагчдын гэр бүлийн харилцаа	✓
Хичээл эхлэхэд сурагчдад тулгамдах бэрхшээл, хүндрэл	✓
Хөл хорионы нөхцөлтэй холбоотой багшийн нийгэм-сэтгэл зүйн асуудал	✓

СУДАЛГААНЫ АРГЫН НАЙДВАРТ ЧАНАР

- Шалгах асуулт: $\alpha=.684 - .878$
- Гэр бүлийн харилцааг үнэлэх асуумж (FAD): $\alpha=.748$
- Нөхцөл байдлыг сэргээн сануулах буюу E-prime-ийн арга, техникийг ашиглахад бага ангийн сурагчид теле хичээлтэй холбоотой болон холбоогүй зурагнуудаас сонголт хийсэн бол дунд, ахлах ангийнхан өгүүлбэр нөхөж бичих даалгавар гүйцэтгэсэн. Судалгаанд оролцсон бага ангийн сурагчид холбоо бүхий 8 зургаас дунджаар 5.6-г олсон бол дунд болон ахлах ангийнхан зөв нөхөх 58 үсгээс дунджаар 55.8 үсгийг бичиж чаджээ. Эндээс харахад, сурагчид тухайн нөхцөл байдлыг бага ангийнхан 70.7 хувь, дунд, ахлах ангийнхан 94.6 хувиар эргэн санаж чадсан байна.

СУДАЛГААНЫ ТҮҮВЭР

Судалгааны түүврийг мужилсан санамсаргүй түүврийн аргаар буюу нийслэл хот, төвийн болон захын дүүргийн орон сууц ба гэр хороолол, аймаг орон нутаг, түүний дотор төвийн, захын болон сумын гэсэн дарааллаар зохион байгуулав. Судалгааны түүвэрт орон нутгийн төлөөллөөр Баянхонгор, Хэнтий аймгууд, хотын төлөөллөөр Улаанбаатар хотын Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийг сонгосон. Хүүхдийн сэтгэл зүйн судалгаа нь цаг хугацаа, хүн хүч их шаарддаг онцлогтой учир магадлалт бус түүвэр хийсэн.

Дээр дурдсан аргачлалын бүрдлээр нэг хүүхэд, эцэг эхээс судалгааны мэдээлэл цуглуулахад дунджаар 45 орчим минут, онцгой тохиолдолд 120 хүртэл минут зарцуулсан.

ХҮСНЭГТ 4. СУДАЛГААНЫ ТҮҮВЭР

	Түүврийн төлөвлөлт	Түүврийн бодит хамрагдалт
ЕБС-ийн бага, дунд, ахлах ангийн сурагчид	270	325
ЕБС-ийн багш нар	82	81
Эцэг эх	82	136*

* Энд сургуулийн өмнөх насны хүүхдийнхээ талаар мэдээлэл өгсөн эцэг эхийн тоо багтсан болно.

Судалгаанд ЕБС-ийн бага, дунд, ахлах ангийн 325 сурагч, тэдний эцэг эх (136), багш нар (81) хамрагдсан. Түүнчлэн судалгаанд оролцсон эцэг эхчүүд (43)-ээс сургуулийн өмнөх насны хүүхдийн нийгэм-сэтгэл зүйн зарим асуудлыг тодруулах мэдээлэл цуглуулсан.

ХҮСНЭГТ 5. СУДАЛГААНЫ ТҮҮВРИЙН БҮТЦИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ

Байршил	Бага ангийн сурагч			Дунд ангийн сурагч			Ахлах ангийн сурагч		Эцэг эх	СӨН-ны хүүхдийнхээ талаар мэдээлэл өгсөн эцэг эх
	1-р анги	3-р анги	5-р анги	6-р анги	8-р анги	9-р анги	10-р анги	11-р анги		
Улаанбаатар	22	25	28	24	16	18	26	27	76	25
Баянхонгор	9	7	11	9	5	9	11	8	30	9
Хэнтий	6	10	9	8	9	8	8	12	30	9

ХҮСНЭГТ 6. СУРАГЧИД (ХҮЙС, БҮС, АНГИ)

Хүйс		Байршил		Анги (насны ангилал)	
Эрэгтэй	49.7%	Хот	57.8%	Бага анги	39.1%
				Дунд анги	32.6%
Эмэгтэй	50.3%	Орон нутаг	42.2%	Ахлах анги	28.3%
Нийт 325					

Судалгаанд оролцсон 81 багш нарын 8 нь эрэгтэй, 73 багш нь эмэгтэй байв.

ЗУРАГ 2. СУДАЛГААНД ХАМРАГДСАН БАГШ НАР (СУРГУУЛИЙН БАЙРШЛААР)**СУДАЛГААНЫ ХЯЗГААРЛАГДМАЛ БАЙДАЛ**

Судалгааны зорилго, арга зүй, гүйцэтгэлийн хугацаа зэргийг үндэслэн энэ удаагийн судалгаанд хөгжлийн бэрхшээлтэй иргэд, амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрх, хүн амын угсаатны бүлгийн цөөнх зэрэг бүлгүүдийн хүрээнд дүгнэлт хийсэнгүй.

Бидний судалгааны мэдээлэл цуглуулж байх цаг үе (7 дугаар сар)-д КОВИД-19 цар тахлын хөл хорионы дэглэм орон нутагт цочроогч байхаа бараг больсон байсан тул хөл хорионы эхэн үеийн сэтгэл зүйн онцлогоос ялгаатай байх боломжтой. Хэрэв уг судалгааг дэлхийн улс орнууд дахь цар тахал дэгдэлтийн эхэн үе буюу 3-4 дүгээр сард зохион байгуулсан бол асуудал өөрөөр харагдах байсан байх талтай хэмээн үзэж байна.

СУДАЛГААНЫ ҮР ДҮН

ХӨЛ ХОРИОНЫ ҮЕИЙН ГЭР БҮЛ, НАЙЗ НӨХДИЙН ХАРИЛЦАА

Сурагчид, эцэг эх, багш нарын гэр бүл, найз нөхдийн харилцааг судалсан үр дүнг нэгтгэн харуулбал:

ЗУРАГ 3. ХӨЛ ХОРИОНЫ ҮЕИЙН ХАРИЛЦААГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ (ХҮҮХЭД, ЭЦЭГ ЭХ, БАГШ НАРЫН ҮНЭЛГЭЭ)




Дээрх зургаас харвал хөл хорионы үед хүүхдүүдийн гэр бүлийн болон найз нөхдийн харилцаа нь “тааруу” үнэлгээтэй байна.

ХҮСНЭГТ 7. БАГА АНГИЙН СУРАГЧИД ӨӨРИЙН ХАРИЛЦААГАА ҮНЭЛСЭН БАЙДАЛ

	Сайн	Хэвийн	Сөрөг
Ээжтэйгээ харилцах	10.1%	50.4%	39.5%
Аавтайгаа харилцах	2.5%	73.1%	24.4%
Ах дүүтэйгээ харилцах	30.8%	46.7%	22.5%


Сургууль хаасан, хөл хорионы үед гэр бүлийнхэн нь өөр хоорондоо муухай ааш гаргах, муудалцах болсон, гэр бүлийн таагүй харилцааны олонх шалтгаан нь хичээлтэй холбоотой гэж бага ангийн сурагчдын 28.8 хувь нь хариулжээ. Мөн бага ангийн сурагчдын 21.7 хувь нь энэ хугацаанд ганцаардаж байсан гэжээ.

ЗУРАГ 4. ГЭР БҮЛИЙН ХАРИЛЦААГАА ҮНЭЛСЭН БАЙДАЛ (ДУНД, АХЛАХ АНГИЙН СУРАГЧИД, ХҮҮХЭД БА ЭЦЭГ ЭХИЙН ХАРИУЛСНААР)



Дунд, ахлах ангийн сурагчдын 50.3 хувь нь гэр бүлийн харилцаагаа “сайн” гэж үнэлсэн бол эцэг эхчүүдийн 47.5 хувь нь “сайн”-аар үнэлжээ. Харин дунд, ахлах ангийн сурагчдын 32.8 хувь нь, мөн эцэг эхчүүдийн 33.9 хувь нь гэр бүлийн харилцаагаа “тааруу” гэж үнэлсэн байна.

ЗУРАГ 5. ГЭР БҮЛИЙН ТААГҮЙ ХАРИЛЦААНЫ ИЛРЭЛҮҮД (ЗАРИМ НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛС)



Судалгаанд хамрагдсан гэр бүлүүдийн таагүй харилцаа дараах байдлаар илэрч байна. Үүнд:

- Бие биедээ муухай ааш гаргах
- Хоорондоо муудалцах
- Бие биеэ гомдоох
- Хоорондоо ярилцахгүй байх
- Гэр бүлийн гишүүд төвөгтэй санагдах
- Ганцаардах

Хөл хорионы үед буюу сургууль, цэцэрлэг түр хаасан хугацаанд гэр бүлийн харилцаанд гарсан өөрчлөлтийн талаар эцэг эхчүүдийн үнэлгээг харвал, тэдний 60 хувь нь өөрчлөлт гараагүй, 40 хувь нь өөрчлөлт гарсан гэж хариулсан. Тухайлбал, илүү ойр дотно болсон, хоорондоо зөрчилддөг болсон, эцэг эхчүүд хүүхэддээ хангалттай хараа хяналт тавьж чадахгүй болсон зэрэг байна.


Гэр бүлийн харилцаанд гарсан өөрчлөлтийг хот, орон нутгийн хувьд харахад, Улаанбаатар хотоос судалгаанд оролцсон эцэг эхчүүдийн 68 хувь нь, орон нутгийн 40 хувь нь гэр бүлийн харилцаанд өөрчлөлт гараагүй гэжээ. Орон нутгийн эцэг эхчүүдийн 37 хувь нь хөл хорио тогтоож, хүүхдүүд сургуульдаа явахгүй гэртээ байснаар “гэр бүлийн гишүүд илүү ойр дотно харилцаатай” болсон гэж хариулсан байна. Гэр бүлийн харилцаанд гарсан өөрчлөлтийг гэр бүлийн гишүүдийн хувьд авч үзвэл аав, өвөө нь хүүхдүүдтэйгээ илүү ойр дотно болсон байна. Мөн гэр бүлийн гишүүдийн тоо нь харилцаатай хэрхэн хамааралтай болохыг шинжлэн харвал, өрхийн ам бүлийн тоо нэмэгдэх тусам зөрчил маргаан нэмэгдэж байна.

ХҮСНЭГТ 8. ХӨЛ ХОРИОНЫ ҮЕ ДЭХ ГЭР БҮЛИЙН ХАРИЛЦААНЫ ЗӨРЧИЛ МАРГААНЫГ ГЭР БҮЛИЙН ГИШҮҮДИЙН ТООГООР ЯЛГАН ХАРУУЛСАН БАЙДАЛ

	Өрхийн ам бүлийн тоо					
	2	3	4	5	6	7
Харилцааны зөрчил маргаантай өрхийн эзлэх хувь	0	0	10	6	14	11

Хөл хорионы үеийн найз нөхдийн харилцаа¹

ЗУРАГ 6. ДУНД, АХЛАХ АНГИЙН СУРАГЧДЫН НАЙЗ НӨХДИЙН ХАРИЛЦАА (ХӨЛ ХОРИОНЫ ӨМНӨ БА ХӨЛ ХОРИОНЫ ҮЕД)



Дунд, ахлах ангийн сурагчдын 76.4 хувь нь хөл хорионы өмнө найз нөхдийн харилцаагаа “эерэг” байсан гэж үнэлсэн бол, 64.3 хувь нь хөл хорионы үеийн найз нөхдийн харилцаагаа “сөрөг” хандлагатай буюу “хөндийрсөн” гэжээ.


1 Найз нөхдийн харилцаанд сурагчдын ангийн хамт олон, дотны найз нөхдийн дотно холбоог авч үзсэн.

Хүүхдийнхээ найз нөхдийн харилцааны талаар эцэг эхчүүдийн 11.8 хувь нь “мэдэхгүй” гэж хариулжээ.

Хөл хорионы үеийн найз нөхдийн харилцааг хот, орон нутгаар нь тодруулж харвал хотын сурагчид найзуудтайгаа харилцах ба уулзалдах нь орон нутгийн сурагчидтай харьцуулбал цөөрсөн үзүүлэлттэй байна.

Хөл хорионы үеийн сурагчдын харилцааны талаарх багш нарын үнэлгээ

ЗУРАГ 7. ГЭР БҮЛИЙН ХАРИЛЦААНЫ ЭЭРЭГ ӨӨРЧЛӨЛТ (БАГШ НАРЫН ХАРИУЛСНААР)



Багш нарын 59 хувь нь хөл хорионы үед сурагчид гэр бүлийнхэнтэйгээ илүүтэй ойлголцож, ойр дотно болсон гэжээ. Түүнчлэн тэдний 26 хувь нь эцэг эхчүүд хүүхдүүдтэй илүү олон цагийг хамтдаа өнгөрүүлж, хүүхэдтэйгээ хамтарч хичээллэх, ойлгохгүй зүйл дээр нь туслах зэргээр хүүхдэдээ тавих анхаарал, халамж нэмэгдсэн гэсэн байна.

Багш нарын 11 хувь нь эцэг эхчүүд хүүхэдтэйгээ илүү ойр дотно харилцаж, анхаарал халамж нэмэгдсэнээр хүүхдийнхээ хувийн онцлог, хүсэл мөрөөдлийг мэдэх, хүүхдийнхээ насны онцлогт тохирсон киног хамт үзэх зэргээр хүүхдээ илүү таньж мэдсэн гэсэн бол 4 хувь нь ахлах ангийн сурагчид ажил хөдөлмөр эрхэлж эцэг эхдээ тусалж байсан нь эерэг өөрчлөлт гэжээ.

ЗУРАГ 8. ГЭР БҮЛИЙН ХАРИЛЦААНЫ СӨРӨГ ӨӨРЧЛӨЛТ (БАГШ НАРЫН ХАРИУЛСНААР)



Багш нарын 31 хувь нь хөл хорионы үед гэр бүлийн харилцаанд сөрөг өөрчлөлт гарсан гэж, 26 хувь нь гэр бүлийн гишүүд хоорондоо ойлголцохгүй болсон гэжээ. Эцэг эхчүүд ажилтай тул бага ангийн хүүхдэдээ анхаарал хандуулж цаг зав гаргахгүй байх, хичээлээ хий гэж улиг болтол шахаж шаардах, эсвэл дүү нарыг нь харуулах, гэрийн ажил хийлгэх зэргээр хүүхдийнхээ үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, хөдөө орон нутагт мал аж ахуйн ажилд туслуулахаар явуулах гэх мэт шалтгаанаас болж хүүхдийнхээ хичээлийг цаг тухайд

нь хийлгээгүйгээс үл ойлголцол үүсч байна гэжээ. Түүнчлэн хүүхдүүд гэр бүлийн таагүй харилцааны улмаас уур бухимдалтай болох, гадуур сэлгүүцэх, цахим хэрэглээ нэмэгдэх зэрэг сөрөг үр дагавартай байна хэмээн багш нар үзэж байна.

"... Эцэг эхчүүд хүүхдийнхээ хичээл даалгаврыг цаг тухайд нь хийлгэдэггүй. Дүн гарах үед багшаа яах билээ гэж холбогддог. Энэ үед хүүхдээ хичээлээр шахах, үүнээс болж зөрчил үүсдэг ... Танхимаар хичээллэж байх үед хичээлээ сайн хийдэг байсан хүүхэд хөл хорионы үед дүү нараа харж, гэрийн ажил хийх гэх мэтээр ачаалал нь нэмэгдсэн ... Гадуур тэнээд байна. Та хэлээд өгөөч гэх мэт ..."

Багшийн ярилцлагаас

Сошиал орчин хөл хорионы үед сурагчид хоорондын харилцааны гол хэрэгсэл болж байгаа төдийгүй тэдний харилцаанд эерэг болон сөрөг үр дагаврын аль алийг бий болгож байна хэмээн багш нар үзэж байна.

ЗУРАГ 9. НАЙЗНӨХӨД, ҮЕ ТЭНГИЙНХНИЙ ХАРИЛЦААНД ГАРСАН ЭЕРЭГ ӨӨРЧЛӨЛТ (БАГШ НАРЫН ХАРИУЛСНААР)



Хөл хорионы үед сурагчид анги хамт олон болон багшаа санах, нэгнийхээ орон зайг илүү ойлгон үгүйлж, бие биеэ санагалзаж байгаа нь үе тэнгийнхний харилцаанд гарсан эерэг өөрчлөлт гэж багш нарын 47 хувь нь үзсэн бол, цахим орчныг зөв ашиглаж хоорондоо мэдээлэл солилцож, хамтарч ажиллаж байсан гэж 34 хувь нь үзсэн байна. Ойролцоо гэртэй сурагчид болон сайн найзуудын хувьд хөл хорионы нөхцөл байдал нь хоорондоо илүү дотносох боломжийг олгосон гэж багш нарын 11 хувь нь үзсэн бол сургууль хичээллэж байхад үе тэнгийнхний дарамтад өртдөг байсан сурагчдын хувьд дарамтад өртөхгүй байх боломжийг хөл хорионы нөхцөл байдал олгосон нь эерэг өөрчлөлт гэж 8 хувь нь үзсэн байна.

"... Ангидаа дээрэлхүүлдэг, үе тэнгийнхний дарамтад өртдөг байсан хүүхдүүдийн хувьд сургууль орохгүй байх нь дарамтад өртөхгүй байх боломжийг олгосон ..."

Багшийн ярилцлагаас

"... Ангийн группт хичээлээ оруулахаар хүүхдүүд даалгавраа явуулдаг. Тэгээд хийсэн даалгавраа бусадтайгаа харьцуулах маягаар ажиллах нь эргээд нэг нэгэндээ үлгэр дуурайл болж байгаа ... Бие биенээ санаад өмнө нь нэг нэгэндээ дургүй байсан хүүхдүүдийн хувьд одоо дотносох байдал ажиглагдсан ... Үе тэнгийнхний дарамтад өртөхгүй байх, уруу татагдах нь бага байсан ..."

Багшийн ярилцлагаас

ЗУРАГ 10. НАЙЗ НӨХӨД, ҮЕ ТЭНГИЙНХНИЙ ХАРИЛЦААНЫ СӨРӨГ ӨӨРЧЛӨЛТ (БАГШ НАРЫН ХАРИУЛСНААР)

Цахим орчинд хэтэрхий их цаг зарцуулж, цахим хэрэглээг хэтрүүлэн буруу хэрэглэж хаалттай групп чат үүсгэн хараа хяналтгүйгээр харилцах, бие биеэ шоолох, доромжилсон өнгө аястай зүйлс бичих, нэгнийгээ гомдоох зэрэг нь үе тэнгийнхний харилцаанд гарч буй сөрөг өөрчлөлт гэж багш нарын 44 хувь нь үзсэн байна. Мөн цахим орчны харилцаа, хэрэглээ нэмэгдсэнээр “амьд” харилцаа багасч сурагчдын нийгэмшихүйд сөргөөр нөлөөлж байгаа нь үе тэнгийнхний харилцаанд гарч буй сөрөг нөхцөл байдал хэмээн багш нарын 28 хувь нь үзжээ. Хөл хорионы үед сурагчид хоорондоо огт харилцахгүй байгаа гэж багш нарын 16 хувь үзсэн бөгөөд энэ нь цаашлаад найзуудаасаа хөндийрөх, үл ойлголцол үүсэх зэрэг сөрөг үр дагавартай хэмээн багш нарын 14 хувь нь үзсэн байна. Багш нарын ярилцлагын мэдээллээс харвал, дунд болон ахлах ангийн сурагчдын тухайд гэр бүлийн гишүүд гэхээсээ илүүтэйгээр сайн найздаа өөрт болон гэр бүлдээ тохиолдсон зүйлсийг ярьж тайвширч, ойлголцдог байсан бол хөл хорионы үед энэ нөхцөл байхгүй болсон гэж багш нар үзэж байна.

ХӨЛ ХОРИОНЫ ҮЕ ДЭХ ХҮҮХДИЙН СЭТГЭЛ ХӨДЛӨЛ, МЭДРЭМЖТЭЙ ХОЛБООТОЙ АСУУДЛУУД

Хөл хорионы үеийн хүүхдийн сэтгэл хөдлөл, мэдрэмжтэй холбоотой зарим асуудлыг хүүхэд, эцэг эхийн үнэлснээр үр дүнг нэгтгэн харуулбал:

ЗУРАГ 11. ХӨЛ ХОРИОНЫ ҮЕИЙН ХҮҮХДИЙН СЭТГЭЛ ХӨДЛӨЛ, МЭДРЭМЖИЙН ҮНЭЛГЭЭ (ХҮҮХЭД, ЭЦЭГ ЭХИЙН ХАРИУЛСНААР)

ХҮҮХЭД	ЭЦЭГ ЭХ
Санаа зовиол, түгшүүр 69.5%	СӨН-ны хүүхэд сөрөг өөрчлөлттэй 25.6%
Ганцаардал 67.8%	Хүүхэд стресс, бухимдалтай 17.7%
Айдас 67.2%	Хүүхэд уйтгар гунигтай 15.3%
Уйтгар гуниг 62.9%	Хүүхэд ганцаардсан 10%
Стресс бухимдал 53.3%	

Айдас

Нэгдүгээр ангийн сурагчдын 60.6 хувь нь КОВИД-19-өөс “айж байна” гэж хариулсан бөгөөд анги ахих тусам уг өвчнөөс айх нь багасаж байна. Харин сурлагын үзүүлэлт, дүн буурахаас айх нь дунд ангийн сурагчдад өндөр байна.

ХҮСНЭГТ 9. ХҮҮХДИЙН АЙЖ БАЙГАА ҮНДСЭН АСУУДЛУУД (БАГА, ДУНД БА АХЛАХ АНГИАР)


		Бага анги	Дунд анги	Ахлах анги
КОВИД-19-өөс айх айдас	Огт үгүй	10.9%	21.3%	15.2%
	Бага	12.0%	19.4%	31.5%
	Дундаж	26.1%	25.9%	26.1%
	Их	51.1%	33.3%	27.2%
Сурлагын дүн буурах айдас	Огт үгүй	12.7%	5.6%	15.2%
	Бага	27.5%	15.7%	13%
	Дундаж	26.5%	24.1%	21.7%
	Их	33.3%	54.6%	50%

Орон нутаг ба хотын дунд, ахлах ангийн сурагчдын сурлагын дүн буурахаас айх айдсыг харьцуулан харвал 7.5 хувийн зөрүүтэй (94.3 хувь ба 86.8 хувь) байна.


Дотоод хандлагыг илрүүлэх тестийн үр дүнгээр дунд, ахлах ангийн сурагчдын 56.5 хувь нь ямар нэг зүйлээс “маш их айж байгаа” гэсний эхний шалтгаануудад КОВИД-19 тархах (36 хувь), хичээлийн агуулгаас хоцорсон, хоцрогдолд орсон байх (20.5 хувь), сургууль дээр хичээллэх нь хойшлох буюу теле-хичээл үргэлжлэх (19 хувь), хичээлийн ачаалалтай болох (1 хувь) зэрэг байна. Дунд ангийн сурагчидтай (46 хувь) харьцуулахад ахлах ангийн сурагчид (54 хувь) илүү айж, санаа зовинож байна. Тухайлбал, ирэх ес дүгээр сарын нэгнээс 12 дугаар анги (төгсөх анги)-д элсэн орох сурагчид их дээд сургуулийн элсэлтийн ерөнхий шалгалт (ЭЭШ)-д илүү их санаа зовж байна.

Санаа зовнил


Нэгдүгээр ангийн сурагчдын 68.8 хувь нь хичээлдээ явж чадахгүй байгаадаа санаа зовж байна. Дунд болон ахлах ангийн сурагчдын хичээлдээ явж чадахгүй байгаадаа санаа зовох нь бага ангийн сурагчдынхаас хоёр дахин бага байна.

ЗУРАГ 12. СУРГУУЛЬ ХААГДСАНААС ХОЙШИХ САНАА ЗОВНИЛ

Шинэ хичээлийн жил эхэлж, есдүгээр сарын нэгнээс хичээл танхимаар орж эхэлбэл санаа зовох зүйл байхгүй гэж 37.2 хувь, харин теле-хичээл үргэлжлэхээр бол санаа зовох зүйл байхгүй гэж 30.4 хувь нь хариулсан байна. Танхимд хичээллэх эсвэл теле-хичээл үргэлжлэхтэй холбоотойгоор сурагчид дараах (Зураг 13) асуудлуудад санаа зовж байна.

ЗУРАГ 13. ШИНЭ ХИЧЭЭЛИЙН ЖИЛ ЭХЛЭХТЭЙ ХОЛБООТОЙГООР СУРАГЧДЫН СЭТГЭЛ ЗҮЙН БЭЛЭН БАЙДАЛ (ТЕЛЕ-ХИЧЭЭЛ БОЛОН ТАНХИМЫН СУРГАЛТ)

Дээрх үр дүнгээс харвал сурагчдын хувьд хамгийн ихээр санаа зовж буй асуудлууд нь танхимын хичээл орох бол сурагчид сурлагаар хоцорсон байх, КОВИД-19 халдвар авах, харин теле-хичээл үргэлжлэхээр бол сурлагаар хоцрохоос, теле-хичээл хэцүү санагдаж, хичээлдээ дургүй байх гэж үзжээ.


ЗУРАГ 14. ХҮҮХДИЙН ГЭР БҮЛИЙНХЭЭ САНХҮҮД САНАА ЗОВНИЖ БҮЙ БАЙДАЛ

Хүүхдүүдийн гэр бүлийнхээ санхүүд санаа зовних нь анги ахих тусам нэмэгдэж байна. Тодруулбал, бага ангийн сурагчдын 49.5 хувь, дунд ангийн сурагчдын 57 хувь, ахлах ангийн сурагчдын 72.8 хувь нь гэр бүлийнхээ санхүүд санаа зовниж байна.

Ганцаардал, уйтгар гуниг

Ганцаардах, уйтгарлах байдал дунд болон ахлах ангийн сурагчдад түгээмэл байна. Сурагчдын 25.8 хувь нь сургууль түр хаагдаж, гэртээ байснаар их ганцаарддаг, 18 хувь нь их уйтгарладаг гэжээ. Хөл хорионы үед дунд болон ахлах ангийн сурагчдын 4 хүүхэд тутмын 1 нь их ганцаардаж, 5 сурагч тутмын 1 нь их уйтгарлаж, уйдаж байна гэжээ.


Дунд болон ахлах ангийн сурагчдын ганцаардах болон уйтгарлах нь хүйсээс хамааралгүй байна.

ЗУРАГ 15. ДУНД БОЛОН АХЛАХ АНГИЙН СУРАГЧДЫН ГАНЦААРДАЛ, УЙТГАР (ХҮЙСЭЭР)


Хүүхдүүд ганцаардаж, уйтгарлах хамгийн түгээмэл 2 шалтгаан ярилцлагаар гарч ирсэн. Үүнд:

- Сургууль болон дугуйландаа явахгүй байх
- Найз нөхөд, ангийнхантайгаа уулзахгүй, ярилцахгүй байх

Ганцаардах нь орон нутгийн болон хотын дунд, ахлах ангийн сурагчдын тухайд ялгаатай байна. Хотын сурагчдын 19.3 хувь нь, орон нутгийн сурагчдын 34.1 хувь нь “их ганцаарддаг” гэсэн бол, харин эсрэгээрээ хотын сурагчдын 36 хувь нь, орон нутгийн сурагчдын 27.3 хувь нь “огт ганцаарддаггүй” гэжээ. Хотын сурагчидтай харьцуулахад орон нутгийн сурагчдад интернет хэрэглэх боломж бага (гэртээ интернет байхгүй тул дата ашигладаг), малчин өрхийн хүүхдүүд сургууль хаасан учраас дотуур байрнаас гарч өрхийн мал аж ахуй ажилд туслахын тулд хөдөө гэр рүүгээ явснаас найз нөхөдтэйгөө холбогдох нь багассан зэрэг үндсэн шалтгаанууд үүнд нөлөөлж байж болзошгүй юм.

ЗУРАГ 16. ХҮҮХДИЙН ГАНЦААРДЛЫГ ХАРЬЦУУЛСАН ҮР ДҮН (ХОТ БА ОРОН НУТАГ)

Судалгаанд оролцсон нийт орон нутгийн хүүхдүүдийн 22.7 хувь, хотын хүүхдүүдийн 14 хувь нь “их уйтгарлаж, уйдаж байна” гэжээ.

ЗУРАГ 17. ХҮҮХДҮҮДИЙН ҮЙТГАРЛАХЫГ ХАРЬЦУУЛСАН ҮР ДҮН (ХОТ БА ОРОН НУТАГ)**Дасан зохицох чадвар, ээнэгшлийн түгшүүр ба стресс, бухимдал**

Дасан зохицох чадварын хувьд нийт хүүхдүүдийн 56.2 хувь нь сул, 43.8 хувь нь өндөр байна. Хэрэв хүний дасан зохицох чадвар сул байвал хүрээлэн байгаа орчин, эргэн тойрны хүмүүстэй зөрчилдөх нь нэмэгдэнэ.

ЗУРАГ 18. ХҮҮХДҮҮДИЙН ДАСАН ЗОХИЦОХ ЧАДВАР

Судалгаанаас үзвэл, хүүхдүүдийн 54.5 хувь нь стресс бухимдалтай байна. Ээнэгшлийн түгшүүр судалгаанд оролцсон нийт хүүхдүүдийн 60 хувьд нь илэрч байна. Дээрх үр дүнг дэлгэрэнгүйгээр хэвийн үзүүлэлттэй² нь харуулбал:

ХҮСНЭГТ 10. СТРЕСС, БУХИМДЛЫН ҮЕИЙН ХАРИУ ҮЙЛДЛИЙГ ХЭВИЙН СТАНДАРТ ҮЗҮҮЛЭЛТТЭЙ ХАРЬЦУУЛСАН ҮР ДҮН (ХАРГАЛЗАХ ОНООГООР)

			Нас				
			6-7	8-9	10-11	12-13	14-өөс дээш
Ангилал	Бусдыг буруутгах хандлага	Стандарт үзүүлэлт	46.3	43.3	39.2	33.3	46-52
		Үр дүн	69.7	61	65.2	66.7	51.4
	Бусдыг болон өөрийгөө үл буруутгах, хариуцлага ба зэмлэлээс зайлсхийх, бэрхшээлээс зугтах хандлага	Стандарт үзүүлэлт	31.3	32.9	35.8	40.4	23-26
		Үр дүн	21.2	24.4	23.9	25.9	44.6
	Сул, эмзэг, хэт мэдрэмтгий, бусдыг буруутгах, өөрийгөө хамгаалах хандлага	Стандарт үзүүлэлт	39.6	42.1	41.7	42.3	35-39
		Үр дүн	48.5	61	69.6	61.1	34.5

Дээрх үр дүнд статистик шинжилгээ хийхэд зарим талаар хүйсийн хувьд ялгаа илэрч байна ($p < .05$). Тодруулбал, охид илүү бэрхшээлд төвлөрсөн байхад, хөвгүүд өөрийгөө хамгаалах болон шийдэлд төвлөрсөн байна. Хүйсийн ялгаатай байдлыг дараах байдлаар тодруулж байна.

ХҮСНЭГТ 11. СТРЕСС БУХИМДЛЫН ҮЕИЙН ХАРИУ ҮЙЛДЛИЙГ ХАРЬЦУУЛСАН ҮР ДҮН (ХҮЙСЭЭР)

2 Стандарт үзүүлэлт нь тухайн насанд байх ёстой хамгийн дээд хэмжээ юм. Судалгаанд хэрэглэсэн Розенцвейгийн арга нь нас тус бүрт харгалзах стандарт үзүүлэлтийг гаргасан байдаг.

	Хөвгүүд	Охид
Бэрхшээлд төвлөрсөн ³	42.3%	57.7%
Өөрийгөө хамгаалсан	50.3%	49.7%
Шийдэлд төвлөрсөн	56.6%	43.4%

Судалгааны үр дүнгээс харвал өөрийгөө хамгаалах хариу үйлдлийн тухайд хүйсийн ялгаа үгүй байна.

Хөл хорионы үед стрессийн шинж тэмдгүүд нэгдүгээр ангийн сурагчдын 53 хувьд, бусад ангийн сурагчдын 48.7 хувьд илэрсэн байна.

ХҮСНЭГТ 12. ХҮҮХДҮҮДЭД ИЛЭРЧ БҮЙ СТРЕССИЙН ШИНЖ ТЭМДГҮҮД (АНГИ БА ХҮЙСЭЭР)

	Бага анги		Дунд анги		Ахлах анги	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
Амархан уурладаг болсон эсэх	63.4%	48.9%	56.1%	75.4%	61.2%	62.8%
Амархан ядардаг болсон эсэх	48.8%	27.7%	51.2%	50.8%	51%	53.5%
Гэдэс нь өвддөг болсон эсэх	24.4%	27.7%	41.5%	24.6%	30.6%	37.2%
Хичээлээ хийх дургүй болсон эсэх	46.3%	52.6%	78%	61.5%	61.2%	69.8%

Хүйсээр харьцуулан харахад, бага ангийн эрэгтэй сурагчдын 63.4 хувь, эмэгтэй сурагчдын 48.9 хувь нь сургуульдаа явахгүй болсноос хойш амархан уурладаг болсон, эрэгтэй сурагчдын 48.8 хувь, эмэгтэй сурагчдын 27.7 хувь нь сургууль хаагдсанаас хойш амархан ядардаг болсон байна. Эндээс үзвэл эмэгтэй, эрэгтэй сурагчдад илрэх стрессийн шинж тэмдгүүд ялгаатай байна.

Дунд, ахлах ангийн сурагчдын уурлах, санаа зовох байдлыг орон нутаг ба хотоор шинжлэн харвал, орон нутгийн сурагчдын тоон үзүүлэлт илүү буюу тэдэнд стрессийн шинж тэмдгүүд олон давтагдаж байна. Тодруулбал, сургуульдаа явахгүй болсноос хойш хотын сурагчдын 58.8 хувь, орон нутгийн сурагчдын 73.9 хувь нь амархан уурладаг болсон төдийгүй хотын сурагчдын 54.9 хувь, орон нутгийн сурагчдын 76.1 хувь санаа зовомтгой болсон гэжээ.

Эцэг эхчүүд хүүхдийн сэтгэл санааг үнэлсэн байдал

Хөл хорионы үед хүүхдийн сэтгэл хөдлөл, зан үйл, бие махбодид өөрчлөлт гарсан эсэхийг эцэг эхчүүдээс тодруулахад, КОВИД-19-өөс санаа зовж, түгших болсон, теле-хичээлээ сайн хийгээгүйгээс санаа зовж, түгших болсон зэрэг өөрчлөлтүүд өндөр хувьтай байна.

3 Бэрхшээлд төвлөрсөн хариу үйлдэл нь бухимдлыг бий болгосон саад бэрхшээлд төвлөрдөг. Өөрийгөө хамгаалсан хариу үйлдэл нь бусдыг буруутгаж, өөрөө буруутгадахаас зайлсхийдэг. Шийдэлд төвлөрсөн хариу үйлдэл нь зөрчилтэй нөхцөл байдалд бүтээлч шийдлийг илэрхийлдэг.

ЗУРАГ 19. ЭЦЭГ ЭХЧҮҮД ХҮҮХДИЙНХЭЭ ХӨЛ ХОРИОНЫ ҮЕИЙН СЭТГЭЛИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ ӨӨРЧЛӨЛТИЙГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Сургуулийг удаан хугацаагаар хаасан нь хүүхдийн сэтгэл санаа, төлөвшил, харилцаанд сөргөөр нөлөөлсөн хэмээн эцэг эхчүүдийн 25.2 хувь нь үзэж байна. Харин 9.6 хувь нь өөрчлөлт гарсан эсэхийг мэдэхгүй гэжээ. Хөл хорионы үеийн хүүхдийн сэтгэл зүйн байдлыг эцэг эхийн хариултад үндэслэн жагсаавал:


- Уйтгар, гунигтай байсан
- Ганцаардсан
- Ууртай болсон
- Гэрийнхэнтэйгээ харилцах нь нэмэгдсэн
- Тогтворгүй байсан
- Хичээлдээ явмаар байна гэж гомдоллодог болсон гэх зэрэг орсон байна.

Эцэг эхчүүдийн үзэж байгаагаар хөл хорионы үед хүүхдүүдийн сэтгэл санааны байдал орон нутаг ба хотод ялгаатай байна. Тухайлбал, орон нутгийн хүүхдүүдэд уйтгар, гунигтай байсан нь хамгийн өндөр хувьтай (37) байгаа бол хотын хүүхдүүдийн тухайд ууртай байсан нь хамгийн өндөр хувьтай (26.2) байна.

ХҮСНЭГТ 13. ХҮҮХДИЙН СЭТГЭЛ САНААНЫ БАЙДЛЫГ ХОТ, ОРОН НУТГААР ХАРЬЦУУЛСАН ҮР ДҮН (ЭЦЭГ ЭХИЙН ХАРИУЛСНААР)

	Хот	Орон нутаг
Уйтгар, гунигтай байсан	16.6%	37%
Ганцаардаж байсан	7.1%	2.2%
Ууртай байсан	26.2%	15.2%
Гэрийнхэнтэйгээ харилцах харилцаа нэмэгдсэн	4.8%	4.3%
Тогтворгүй байсан	6%	0%
Хичээлдээ явмаар байна гэж гомдоллодог болсон	10.7%	8.7%

Судалгаанд оролцсон эцэг эхийн 31.6 хувь нь сургуулийн өмнөх насны хүүхэдтэй байсан. Эдгээр эцэг эхчүүдийн 25.6 хувь нь хөл хорионы үед сургуулийн өмнөх насны хүүхдийнх нь зан ааш, сэтгэл зүй өмнөхөөс өөрчлөгдсөн гэж үзэж байна.

ЗУРАГ 20. ХӨЛ ХОРИОНЫ ҮЕИЙН СӨН-НЫ ХҮҮХДИЙН СЭТГЭЛ ЗҮЙН БАЙДАЛ (ЭЦЭГ ЭХИЙН ХАРИУЛСНААР)

Энэ хэсэгт хэдий цөөн тооны эцэг эх, хүүхдийг хамруулсан ч хөл хорио нь СӨН-ны хүүхдийн зан ааш өөрчлөгдөх, уйтгарлах, зожгирах, цахим хэрэглээ нэмэгдэх зэргээр хүүхдийн зан үйлд сөргөөр нөлөөлж байна.

Хөл хорионы үеийн хүүхдийн зан үйлтэй холбоотой асуудлууд

Сургууль хаасан хугацаанд бага ангийн сурагчдын 44.4 хувь, дунд ангийн сурагчдын 13.2 хувь, ахлах ангийн сурагчдын 17.4 хувь нь хөдөлгөөн багассан, хөдөлгөөний дутагдал ихтэй гэсэн бол, бага ангийн сурагчдын 6.7 хувь, дунд ангийн сурагчдын 14.2 хувь, ахлах ангийн сурагчдын 16.3 хувь жин их нэмсэн гэжээ. Сурагчдын жин нэмэгдсэн нь зөвхөн бага ангийнханд хүйсийн ялгааны тоон утга харагдаж байна. Тухайлбал, сургууль хаасан хугацаанд бага ангийн эрэгтэй сурагчдын 81.0 хувь, эмэгтэй сурагчдын 93.8 хувь нь жин нэмсэн гэжээ.

Түүнчлэн дунд (38.7 хувь) болон ахлах (44.6 хувь) ангийн сурагчдын нойрны дэглэм их алдагдаж, гурван хүүхэд тутмын нэгийнх нь цагийн зохицуулалт их замбараагүй болсон байна.


ХҮСНЭГТ 14. ГЭРТЭЭ УДААН ХУГАЦААГААР БАЙХ, ХИЧЭЭЛЭЭ ХИЙХ НЬ СУРАГЧДАД ХҮНДРЭЛТЭЙ БАЙГАА ЭСЭХ (ХҮҮХДҮҮДИЙН ХАРИУЛСНААР)

		Бага анги	Дунд анги	Ахлах анги
Хөдөлгөөний дутагдалд орж буй эсэх	Огт үгүй	12.2%	46.2%	38%
	Бага	16.7%	20.8%	18.5%
	Дундаж	26.7%	19.8%	26.1%
	Их	44.4%	13.2%	17.4%
Сургууль хаагдсанаас хойш жин нэмсэн эсэх	Огт үгүй	40 %	28.3%	51.1%
	Бага	40 %	33%	15.2%
	Дундаж	13.3%	24.5%	17.4%
	Их	6.7%	14.2%	16.3%
Нойрны дэглэмд өөрчлөлт орсон эсэх	Огт үгүй	37.8%	18.9%	5.4%
	Бага	18.9%	15.1%	23.9%
	Дундаж	22.2%	27.4%	26.1%
	Их	21.1%	38.7%	44.6%
Цаг зохицуулалт замбараагүй болсон эсэх	Огт үгүй	37.8%	20.8%	13%
	Бага	21.1%	27.4%	18.5%
	Дундаж	22.2%	20.8%	34.8%
	Их	18.9%	31.1%	33.7%

Орон нутгийн бага ангийн сурагчид өөрсдийгөө хөдөлгөөний дутагдалд ороогүй гэж үзэж байгаа бол дунд ангийн сурагчдын 53.8 хувь, ахлах ангийн сурагчдын 62 хувь нь тус тус өөрийгөө хөдөлгөөний дутагдалд орсон гэжээ.


Хөл хорионы хугацаанд хотын дунд ба ахлах ангийн сурагчдын 84.2 хувь, орон нутгийн сурагчдын 92 хувьд нь нойрны дэглэмийн өөрчлөлт гарсан байна.

ЗУРАГ 21. ХӨДӨЛГӨӨН БАГАСАН ГЭДГИЙГ ХАРЬЦУУЛСАН ҮР ДҮН (ХҮЙСЭЭР)



Нэгдүгээр ангийн сурагчдын гар утасны хэрэглээ нэмэгдсэн эсэхийг тодруулахад 72.7 хувь нь гар утсаар тоглож, бичлэг үзэх нь нэмэгдсэн гэж хариулжээ. Нэгдүгээр ангиас бусад ангийн сурагчдын 66.7 хувь нь фэйсбүүкийн хэрэглээ нэмэгдсэн, 50 хувь нь цахим тоглоом (Mobilelegend, PUB G, Force Horizon)-ын хэрэглээ нэмэгдсэн, 60.6 хувь нь бусад цахим сүлжээ (инстаграм, U-Tube, тикток, твиттер гэх мэт)-г ашиглах хугацаа нэмэгдсэн гэжээ.

ЗУРАГ 22. НЭГДҮГЭЭР АНГИАС БУСАД АНГИЙН СУРАГЧДЫН ЦАХИМ ХЭРЭГЛЭЭ (ЦАГААР)



Цахим орчинд хүүхдүүдийн хамгийн их хийж байгаа зүйл нь бичлэг (фэйсбүүк, U-Tube, тикток) үзэх байна.

Хөл хорионы үед хүүхдийн сэтгэл хөдлөл, зан үйл, бие махбодод өөрчлөлт гарсан эсэхийг эцэг эхчүүдээс тодруулахад дэлгэцийн хэрэглээ их, анхаарал нь төвлөрөхгүй байх зэрэг хариулт хамгийн өндөр хувьтай байна. Эцэг эхчүүдийн хүүхдэдээ гарсан өөрчлөлтийг үнэлсэн байдлыг доорх хүснэгтэд харуулав.

ХҮСНЭГТ 15. ХӨЛ ХОРИОНЫ ҮЕИЙН СУРАГЧДЫН БИЕ МАХБОД, ЗАН ҮЙЛИЙН ӨӨРЧЛӨЛТ
(ЭЦЭГ ЭХИЙН ХАРИУЛСНААР)

Бие махбодын хувьд	1. Хөдөлгөөний дутагдалд орсон	64.4%
	2. Илүү амархан ядардаг болсон	61.1%
	3. Биеийн жин нэмэгдэж байгаа	59.8%
	4. Толгой нь өвдөх болсон	42 %
	5. Хоол боловсруулах үйл ажиллагаа хямрах болсон (гүйлгэх, өтгөн хатах, гэдэс өвдөх, хоолны дуршил буурах гэх мэт)	37.9%
Зан үйлийн хувьд	1. Дэлгэцний хэрэглээ (гар утас, компьютер, ТВ) нь их болсон	82.6%
	2. Анхаарал нь төвлөрөхгүй байгаа ажиглагдсан	80.3%
	3. Нойрны дэглэм алдагдсан (оройтож унтах, оройтож босох гэх мэт)	75.8%
	4. Хичээл хийх дургүй болсон	74.2%
	5. Илүү их түрэмгий зан гаргах болсон (гэр бүлийнхэнтэйгээ зөрчилдөх, маргалдах нь ихэссэн)	64.4%
	6. Аав, ээждээ элдэв шаардлага тавих нь олон болсон	58.3%

Эцэг эхчүүдийн 45 хувь нь хүүхдийнхээ цахим хэрэглээг нэмэгдсэн гэж үзжээ. Үүнээс 51.3 хувь нь фэйсбүүкт (facebook), 40.3 хувь нь цахим тоглоомд зарцуулах хугацаа нэмэгдсэн гэсэн байна.

ХҮСНЭГТ 16. ХӨЛ ХОРИОНЫ ҮЕИЙН СУРАГЧДЫН ХОНОГИЙН ЦАХИМ ХЭРЭГЛЭЭ (ЭЦЭГ ЭХИЙН ХАРИУЛСНААР)

Фейсбүүк хэрэглээ (Хэрэглэдэггүй 13.8%)		Цахим тоглоом (тоглодоггүй 25.7%)		Бусад	
Байнга хэрэглэдэг болсон	19.5%	Нэмэгдээгүй	12.6%	Нэмэгдсэн	43.9%
Нэмэгдээгүй	18.7%	Байнга тоглодог болсон	11.9%	Нэмэгдээгүй	38.3%
1 цаг орчим нэмэгдсэн	9.8%	1-2 цаг орчим тоглодог болсон	11 %	Сайн мэдэхгүй байна	10.3%
2-3 цаг нэмэгдсэн	9.8%	5-аас дээш цаг тоглодог болсон	5.5%	Телевиз их үздэг болсон	7.5%
4-5 цаг нэмэгдсэн	4.9%	2-3 цаг орчим тоглодог болсон	4.6%		
6 цагаас дээш нэмэгдсэн	4.9%	3-4 цаг тоглодог болсон	4.6%		
Сайн мэдэхгүй байна	4.1%	Заримдаа тоглодог болсон	2.8%		
Даалгавар хийх зорилготойгоор нэмэгдсэн	2.4%				
Багассан	0.8%				

Эцэг эхчүүдийн 4.9 хувь нь хүүхдийнхээ хоногийн цахим хэрэглээг 6-аас дээш цагаар нэмэгдсэн, 11.9 хувь нь байнга буюу өдөр бүр цахим тоглоом тоглодог болсон, 4.6 хувь нь хоногт “3-4 цаг цахим тоглоомоор тоглож байна” гэж үнэлсэн байна.

ХҮСНЭГТ 17. ХӨЛ ХОРИОНЫ ҮЕИЙН ХҮҮХДИЙН ЦАХИМ ХЭРЭГЛЭЭГ ХОТ, ОРОН НУТГААР ХАРЬЦУУЛСАН ҮР ДҮН (ЭЦЭГ ЭХИЙН ХАРИУЛСНААР)

		Хот	Орон нутаг
Фейсбүүк хэрэглээ	Нэмэгдээгүй	18.1%	20%
	Хэрэглэдэггүй	15.7%	10%
	Байнга хэрэглэдэг болсон	21.7%	15%
	1 цаг орчим нэмэгдсэн	9.6%	10%
	2-3цаг нэмэгдсэн	8.4%	12.5%
	4-5цаг нэмэгдсэн	4.8%	5%
	6 цагаас дээш хугацаагаар нэмэгдсэн	6%	2.5%
	Даалгавар хийх зорилготойгоор нэмэгдсэн	2.4%	2.5%
	Багассан	1.2%	0%
	Сайн мэдэхгүй байна	4.8%	2.5%
Цахим тоглоом	Нэмэгдээгүй	21.6%	2.9%
	Тоглодоггүй	20.3%	37.1%
	Байнга тоглодог болсон	17.6%	0%
	Заримдаа тоглодог болсон	0%	8.6%
	1-2 цаг орчим тоглодог болсон	12.2%	8.6%
	2-3 цаг орчим тоглодог болсон	5.4%	2.9%
	3-4 цаг тоглодог болсон	4.1%	5.7%
	5-аас дээш цагаар тоглодог болсон	8.1%	0%

Эцэг эхийн хариулснаар цахим хэрэглээ хот болон орон нутагт ялгаатай байна. Тухайлбал, хотод 21.7 хувь нь байнга фейсбүүк хэрэглэдэг гэсэн бол орон нутагт 15.0 хувьтай байна. Түүнчлэн хотын хүүхдүүдийн 20.3 хувь нь, орон нутгийн хүүхдүүдийн 37.1 хувь нь цахим тоглоомоор тоглодоггүй гэжээ. Сургууль хаасан, хөл хорионы үед хичээл, даалгавар хийх зорилгоор сурагчдын фейсбүүк хэрэглээ нь хотод 2.4 хувиар, орон нутагт 2.5 хувиар тус тус нэмэгдсэн байна.

Эцэг эхээс хөл хорионы үед хүүхдүүд хичээл хийх, даалгавраа хийх, амрах цагаа зохицуулж чаддаг байсан эсэхийг тодруулахад:

- Зохицуулж чаддаг байсан 46.7 хувь
- Зохицуулж чаддаггүй байсан 45.2 хувь
- Заримдаа зохицуулж чаддаггүй байсан 8.1 хувь гэжээ.

Түүнчлэн цагаа хэрхэн зохицуулж байсан шийдлийг тодруулахад 17.4 хувь нь цагийн хуваарь гаргасан, 16.5 хувь нь өөртөө шаардлага тавьсан гэжээ.


ХҮСНЭГТ 18. ХҮҮХДИЙН ЦАГАА ЗОХИЦУУЛАХ БАЙДЛЫГ ХОТ, ОРОН НУТГААР ХАРЬЦУУЛСАН ҮР ДҮН (ЭЦЭГ ЭХИЙН ХАРИУЛСНААР)

	Хот	Орон нутаг
Цагаа зохицуулж чаддаггүй байсан	47.1%	42%
Цагаа зохицуулж чаддаг байсан	44.7%	50%
Заримдаа зохицуулж чаддаггүй байсан	8.2%	8%
Цагийн хуваарь гаргаж байсан	18.8%	13.9%
Өөртөө шаардлага тавьдаг байсан	14.1%	22.2%

Теле-хичээлийн үеийн хүүхдийн сэтгэл зүйн онцлог


Сургууль хаасан буюу хөл хорио тогтоосон 2020 оны 2-5 дугаар сард хүүхдүүдийн теле-хичээл хийж байх үеийн нөхцөл байдлыг E-prime арга-техникийг ашиглан сэргээн сануулж шинжилсэн. 2-6 сарын өмнөх хугацааны нөхцөл байдлыг сэргээн сануулах туршилт-судалгааг зохион байгуулахад бага ангийн сурагчид 70.7 хувь, дунд ба ахлах ангийн сурагчид 94.6 хувийг сэргээн санаж чадсан.

ЗУРАГ 23. СУРАГЧДАД ТЕЛЕ-ХИЧЭЭЛ ҮЗЭЖ БАЙХ ҮЕД ТУСАЛЖ БАЙСАН ХҮМҮҮС




Хөл хорионы үед сурагчид теле-хичээл хийж байхдаа ойлгомжгүй зүйл гарахад аав ээжээсээ (57.8 хувь), багшаасаа (42.2 хувь), ах эгчээсээ (38.5 хувь) тусламж авч байжээ. Хэнээс ч тусламж аваагүй гэж нийт сурагчдын 6.2 хувь нь хариулжээ. Мөн теле-хичээл хийж байх үед ойлгохгүй зүйлийг хэнээс ч асуудаггүй гэж хоёр сурагч тутмын нэг нь хариулсан байна.

ЗУРАГ 24. СУРАГЧДЫН ТЕЛЕ-ХИЧЭЭЛ ҮЗЭЖ БАЙХ ҮЕД “БУСДААС ХОЦРОХ БАЙХ” ГЭСЭН САНАА ЗОВНИЛ (ХҮҮХДҮҮДИЙН ХАРИУЛСНААР)




Теле-хичээл хийж байх үед сурагчдын 50.2 хувь нь маш их болон ихэнх тохиолдолд санаа зовдог байжээ. Түүнчлэн орон нутгийн сурагчдын 59.7 хувь, хотын сурагчдын 43.5 хувь нь бусад хүүхдээс хоцорсон байх гэсэн айдастай байна.

ЗУРАГ 25. СУРАГЧДЫН ТЕЛЕ-ХИЧЭЭЛ ҮЗЭЖ БАЙХ ҮЕИЙН ИНТЕРНЕТТЭЙ ХОЛБООТОЙ САНАА ЗОВНИЛ (ХҮҮХДҮҮДИЙН ХАРИУЛСНААР)




Ахлах ангийнхны 53.5 хувь, дунд ангийнхны 32.5 хувь, бага анийнхны 14 хувь нь теле-хичээл хийж байх үед интернетийн холболт тасрахаас айж байсан гэжээ.

ЗУРАГ 26. СУРАГЧДЫН ТЕЛЕ-ХИЧЭЭЛЭЭ ОЙЛГОХГҮЙ, МУУ ДҮН АВАХААС АЙХ АЙДАС (ХҮҮХДҮҮДИЙН ХАРИУЛСНААР)




Муу дүн авах гэсэн айдсыг бага, дунд, ахлах ангийн сурагчдын хувьд ялгаа байгаа эсэхэд статистик шинжилгээ хийж үзвэл дунд (41.1 хувь), ахлах (46.7 хувь) ангийн сурагчид бага ангийнхан (12.2 хувь)-аас илүү айдастай байна ($p < .05$). Харин хот болон орон нутгийн сурагчдын хувьд илэрхий ялгаатай байдал ажиглагдсангүй.

ЗУРАГ 27. СУРАГЧДЫН ТЕЛЕ-ХИЧЭЭЛИЙН ДААЛГАВРЫН ХУГАЦААТАЙ ХОЛБООТОЙ САНДАРЧ ТЭВДЭХ БАЙДАЛ (ХҮҮХДҮҮДИЙН ХАРИУЛСНААР)



Дээрх зургаас харвал, теле-хичээл үзэж байх хугацаанд нийт сурагчдын талаас илүү нь байнга болон заримдаа сандардаг, харин зөвхөн арван хүүхэд тутмын нэг нь огт сандардаггүй гэсэн байна.

ЗУРАГ 28. СУРАГЧДЫН ТЕЛЕ-ХИЧЭЭЛТЭЙ ХОЛБООТОЙ БУХИМДЛЫН ШАЛТГААН (ХҮҮХДҮҮДИЙН ХАРИУЛСНААР)

Сурагчдын ихэнх нь буюу 65-аас илүү хувь нь теле-хичээл хийж байх үедээ маш их даалгавар өгдөг, даалгавар хийх хугацаа бага гэдэгт бухимдаж байсан байна.

Гэртээ удаан хугацаагаар байхад хэцүү байгаагүй гэж сурагчдын 14.6 хувь нь хариулсан. Харин “хэцүү” байсан гэж хариулсан сурагчдын 28.4 хувь нь гэрээс гарахгүй, гадаа тоглохгүй, зүгээр суухаар уйдаж ганцаардаж, ойр ойрхон уур хүрдэг гэжээ. Гэртээ байхад “хэцүү” байсан гэсэн сурагчдын 3.4 хувь нь сургуулийн танхимд хичээллэхгүй, 5.2 хувь нь багштайгаа харилцахгүй, 23.1 хувь нь ангийнхан болон найз нөхөдтэйгөө хамт хичээллэж тоглохгүй, багш ангийнхнаа санаж байсан нь “хэцүү” байна гэжээ.

ЗУРАГ 29. ХҮҮХДҮҮДЭД ГЭРТЭЭ УДААН ХУГАЦААГААР БАЙХАД ТУЛГАРСАН БЭРХШЭЭЛ (ХҮҮХДҮҮДИЙН ХАРИУЛСНААР)

Нэгдүгээр ангийн эрэгтэй сурагчдын 66.7 хувь нь, эмэгтэй сурагчдын 77.1 хувь нь гэртээ удаан байхад муухай байсан гэжээ. Бусад ангийн сурагчдын тухайд хүйсийн ялгаа ажиглагдсангүй. Хотын бага ангийн сурагчдын 83 хувь, орон нутгийн бага ангийн сурагчдын 56.8 хувь “гэртээ удаан байхад муухай байна” гэж хариулжээ.

Хичээл хийх, амрах цагаа зохицуулахад хүндрэл гарсан эсэхийг тодруулахад 46 хувь цагаа зохицуулж чадсан гэж хариулсан. Харин цагаа зохицуулахад хүндрэлтэй байсан сурагчдын 36.9 хувь нь тулгарсан нөхцөл байдлыг шийдвэрлэхийн тулд дараах арга хэмжээг авсан байна. Үүнд:

ХҮСНЭГТ 19. ХҮҮХДҮҮДИЙН ХИЧЭЭЛЭЭ ХИЙХ, АМРАХ ЦАГАА ЗОХИЦУУЛСАН АРГУУД

Хичээл, гэрийн ажил хийх, амрах хуваарь гаргасан, завсарлага авсан	62.8%
Хоцорсон хичээлээ нөхөж хийдэг байсан	17.4%
Оройн цагаар хичээлээ хийсэн (шөнө, чимээгүй орчин бүрдүүлсэн)	9.3%
Бусдаас тусламж авсан (аав, ээжээрээ туслуулах, зөвлөгөө авах, ах дүүтэйгээ ээлжилж хичээлээ хийх)	8.1%
Амрах цагаа хассан	2.3%


Хичээл болон даалгавраа хийх, амрах цагаа зохицуулж чадахгүй байх нь бага ангийн сурагчдын 46.7 хувьд, дунд ангийн 49.5 хувьд, ахлах ангийн сурагчдын 66.3 хувьд тулгарсан байна. Ахлах болон дунд ангийн сурагчдын хувьд хичээл хийх, амрах дэглэм алдагдсан байдлыг хүйсээр харьцуулахад эрэгтэй сурагчдын 89.1 хувь, эмэгтэй сурагчдын 76.4 хувьтай байна. Бага ангийн сурагчдад хүйсээс шалтгаалсан ялгаа, дэглэм, цагийн зохион байгуулалт дээр гарсангүй.

Судалгаанд оролцсон нэгдүгээр ангийн сурагчдын 39.4 хувь, 3 болон 5-р ангийн сурагчдын 24.4 хувь, дунд болон ахлах ангийн сурагчдын 17.3 хувьд нь гэртээ хичээллэх “хэцүү” байгаагүй байна. Сурагчдын 12.4 хувь нь гэртээ хичээллэх нь тайван тухтай (чимээгүй, ангид хүүхдүүд шуугилддаг, анхаарал төвлөрдөг), уян хатан цагтай (хичээлээ хийчихээд амарч болно) байдаг гэж хариулжээ. Хүүхдүүдийн 72.9 хувь нь гэртээ хичээллэх нь “хэцүү” гэж үзэж байна.

ХҮСНЭГТ 20. ГЭРТЭЭ ХИЧЭЭЛЛЭХ НЬ ХҮҮХДЭД ХҮНДРЭЛТЭЙ БАЙГАА ЭСЭХ (ХҮҮХДҮҮДИЙН ХАРИУЛСНААР)

	Бага анги	Дунд анги	Ахлах анги
Огт үгүй	24.4%	15.1%	18.5%
Бага	24.4%	20.8%	18.5%
Дундаж	18.9%	25.5%	22.8%
Их	32.2%	38.7%	40.2%


Хотын нэгдүгээр ангийн сурагчдын 47.4 хувь, орон нутгийн нэгдүгээр ангийн сурагчдын 78.6 хувь нь гэртээ хичээллэх нь хэцүү байсан гэжээ. Гэртээ хичээллэхэд хэцүү байсан гэж хариулсан нийт сурагчдын хувьд хичээл хийх ширээ, сандалтай болон гэрийн интернеттэй эсэх нь дээрх хариултыг өгөхөд нөлөөлсөн байж болзошгүй байна. Учир нь гэрийн интернеттэй болон интернетгүй байх хариулт дээр 9 хувийн ялгаатай байдал харагдаж байна.

ЗУРАГ 30. ГЭРТЭЭ ХИЧЭЭЛЛЭХЭД ХҮНДРЭЛТЭЙ БАЙХАД НӨЛӨӨЛЖ БУЙ ОРЧНЫ ХҮЧИН ЗҮЙЛ

Теле-хичээлийг ойлгосон байдал, тулгарсан бэрхшээл

Бага ангийн сурагчдын 76.6 хувь, дунд ангийнхны 42.1 хувь, ахлах ангийнхны 30.4 хувь нь теле-хичээлийг хийх дуртай байсан гэжээ. Дэлгэрэнгүй мэдээллийг зураг 31-ээс харна уу.

ЗУРАГ 31. ТЕЛЕ-ХИЧЭЭЛЭЭ ХИЙСЭН ТУХАЙГАА ҮНЭЛСЭН ҮР ДҮН (ХҮҮХДҮҮДИЙН ХАРИУЛСНААР)



Нэгдүгээр ангийн сурагчдын 69.7 хувьд теле-хичээл хийх үед хэцүү байсан бөгөөд тэдний хариулснаар теле-хичээлийн хэцүү гэх нийтлэг буюу олон давтамжтай шалтгааныг жагсаавал (дэлгэрэнгүйг зураг 32-аас харна уу),

- Хичээлийн цаг хурдан дуусдаг
- Бичиж амждаггүй
- Багшийн яриаг ойлгодоггүй
- Даалгавар их өгдөг зэргийг дурдсан байна.

Теле-хичээлийн үед нэгдүгээр ангийн гурван сурагч тутмын нэг нь багшийн яриаг ойлгодоггүй гэжээ.

Бусад шалтгааны тухайд эцэг эх нь их шахдаг байсан, сайн харахгүй байсан, үзсэн зүйлийг маань давтаж заадаг байсан зэрэг шалтгаануудыг сурагчид нэрлэсэн байна.

Нэгдүгээр ангиас бусад ангийн сурагчдад теле-хичээлийн үед хамгийн их түгээмэл тулгарсан бэрхшээлүүдийг 3 бүлэгт багцлан дараах зургаар харуулав.

ЗУРАГ 32. ТЕЛЕ ХИЧЭЭЛИЙН ҮЕД ТУЛГАРСАН ТҮГЭЭМЭЛ БЭРХШЭЭЛ (НЭГДҮГЭЭР АНГИАС БУСАД АНГИЙН СУРАГЧДЫН ХАРИУЛСНААР)



Бусад бэрхшээлүүдийн тухайд, тайлбарлуулах хүн байхгүй, амьд харилцаа биш (7.6 хувь), залхсан, сонирхолгүй, уйтгартай (3.5 хувь), теле-хичээл үзээгүй, амжихгүй, хөдөө явсан, хичээлийн цагаа мартаж гэх зэрэг (2.2 хувь), багш нарын арга барил таарахгүй (1.9 хувь), хичээлийн агуулга шахуу байсан, бүрэн бүтэн ороогүй, заримдаа агуулга давхцах (1.9 хувь), теле-хичээлийн дүрс нь харагдахгүй байсан (1.6 хувь), нүд өвдөх, хараа муудах зэргээс айх


(1.3 хувь), хичээлийн цагийн хуваарь тохиромжгүй (1.3 хувь), теле-хичээлийн болон ангийн багшийн даалгавар давхцах (1 хувь) зэргийг дурдсан.

Дээрх бэрхшээлүүдийн шалтгааны хамгийн олон давтамжтай хариултуудыг жагсаавал:

- Хичээлээ ойлгохгүй (багшаас асуух боломжгүй, багш нарын хараа хяналтгүй), туслалцаа авах нь бага (33.7 хувь)
- Таатай орчин бүрдэхгүй байх (анхаарал сарних, чимээтэй, дүү нар шуугих, ангийнхан биш ах эгчтэйгээ хамт хичээл хийх хэцүү, гэрийн ажил, хичээлийн хэрэглэгдэхүүн байхгүй, ширээ сандалгүй (19.9 хувь)
- Бусадтай харилцах боломжгүй, найзуудаасаа асуух, амьд харилцаа үүсгэх боломжгүй гэх мэт (18 хувь)
- Уйдаx, ганцаараа хийхээр сонирхолгүй, залхуурах (11.4 хувь)
- Хичээлийн цаг бага, теле-хичээлд дургүй, багш нарын арга барил тохирохгүй (4.2 хувь)
- Хичээлээ зурагтаар үзэх нь нүдний хараанд муугаар нөлөөлсөн (0.3 хувь)

Сурагчдын 50.8 хувьд нь теле-хичээлийн үед багш нараас тусламж авах хэрэгцээ гарч байсан байна.


ЗУРАГ 33. СУРАГЧДЫН ТУСЛАМЖ АВАХЫГ ХҮСЧ БАЙСАН ХҮМҮҮС (ХҮҮХДҮҮДИЙН ХАРИУЛСНААР)




Эцэг эхчүүд хүүхдийнхээ теле-хичээлээ хийсэн байдлыг үнэлсэн нь

Эцэг эхчүүдийн 50 хувь нь хүүхдээ теле-хичээлийг тогтмол үздэг байсан гэсэн хэдий ч орон нутаг болон хотод тодорхой үзүүлэлтүүдээр ялгаатай байна. Тухайлбал орон нутгийн эцэг эхчүүдийн 64.4 хувь нь хүүхэд нь теле-хичээлдээ дуртай гэсэн бол, хотын эцэг эхчүүдийн 31.8 хувь нь хүүхэд нь теле-хичээлд дуртай, гуравны нэг нь дургүй, гуравны нэг нь хэлж мэдэхгүй гэжээ.

ЗУРАГ 34. ЭЦЭГ ЭХЧҮҮДИЙН ХҮҮХДИЙНХЭЭ ТЕЛЕ-ХИЧЭЭЛИЙН ОРОЛЦООГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ





Хүүхэд болон эцэг эхчүүдтэй ярилцах явцад дараах кейсүүд тохиолдож байсан. Тухайлбал:

“Сургуулийн өмнөх насны болон сургуулийн насны 2 болон түүнээс олон хүүхэдтэй өрх нэг зурагттай байсан нь хүүхдүүдийн хичээлийн цаг давхцсан нөхцөлд хэн нэг нь л хичээлээ хийж амждаг”.

“Олон буюу 3-аас дээш тооны хүүхэдтэй өрхийн хүүхдүүдээс бага ангийнхан л хичээлээ хийж амждаг. Сургуулийн өмнөх болон дунд, ахлах ангийнхан өдөр бүр теле-хичээл үзэх боломжгүй байдаг. Учир нь бага ангийн багш хичээлийн гүйцэтгэлийг ангийн багш нь өдөр бүр шалгадаг байсан”.

“Малчин өрхийн хүүхдүүдийн өрхийн мал аж ахуйд туслах цаг нь теле-хичээлийн цагтай Давхцдаг тул теле-хичээлээ байнга үзэж чаддаггүй байсан”.

Эцэг эхчүүдийн ярилцлагаас


ХӨЛ ХОРИОНЫ ҮЕИЙН МАЛЧИН ӨРХИЙН ХҮҮХДҮҮДИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

(Дэлгэрэнгүйг зураг 35-аас харна уу).

Судалгааны мэдээлэлд үндэслэн хөл хорионы үеийн малчин өрхийн хүүхдүүдийн нөхцөл байдлыг дараах байдлаар тодруулж байна. Үүнд:

- 89.5 хувь нь ганцаардсан бөгөөд энэ нь бусад хүүхдүүдийнхээс 24 хувиар илүү
- 46.7 хувь нь найзуудтайгаа уулзалдах нь багассан байгаа нь бусад хүүхдүүдийнхээс 28.9 хувиар илүү
- 42.1 хувь жин нэмсэн нь бусад хүүхдүүдийнхээс 20.7 хувиар бага
- 31.6 хувь нь хөл хорионы үед гэрийнхэнтэй урьдынхаас илүү муудалцах болсон нь бусад хүүхдүүдийнхээс 22 хувиар бага
- 36.4 хувийн нойрны дэглэм өөрчлөгдсөн байгаа нь бусад хүүхдүүдийнхээс 29.4 хувиар бага
- 37.5 хувь нь ээж, 33.3 хувь нь ах, эгч нараасаа теле-хичээлээ хийхэд тусламж авсан байсан нь бусад хүүхдүүдийнхээс 10 хувиар илүү байна. Харин 20.8 хувь нь багш, 4.2 хувь нь найзуудаасаа хичээлээ хийхэд тусламж авч байсан нь бусад хүүхдүүдийнхээс 10 хувиар бага байна.


ЗУРАГ 35. МАЛЧИН ӨРХИЙН ХҮҮХДҮҮДИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ



Малчин өрхийн бага ангийн хүүхдүүдийн 73.3 хувь нь теле-хичээл хийх дуртай байсан бол бусад хүүхдүүдийн 46.4 хувь нь дуртай байсан гэжээ.

Теле-хичээлийн үед малчин өрхийн хүүхдүүд хичээлээ хийхдээ гэр бүл, найз нөхдөөсөө доорх байдлаар тусламж авч байсан байна.


ЗУРАГ 36. МАЛЧИН ӨРХИЙН ХҮҮХДҮҮДИЙН ТЕЛЕ-ХИЧЭЭЛД ГЭР БУЛИЙН ГИШҮҮД НЬ ТУСАЛСАН БАЙДАЛ



ХӨЛ ХОРИОНЫ ҮЕД ЭЦЭГ ЭХ, БАГШ НАРТ ТУЛГАМДСАН АСУУДАЛ, БЭРХШЭЭЛ


Өрхийн орлого: Судалгаанд оролцсон эцэг эхчүүдийн 57.8 хувь хөл хорионы дэглэм өрхийн орлого, санхүүд нөлөөлсөн гэсэн бол 42.2 хувь нь нөлөөлөөгүй гэжээ.

ЗУРАГ 37. ӨРХИЙН ОРЛОГО ӨӨРЧЛӨГДСӨН ШАЛТГААН



Өрхийн орлогод нөлөөлсөн шалтгааныг орон нутаг ба хотоор шинжлэн харвал:

ЗУРАГ 38. ӨРХИЙН САНХҮҮГИЙН ӨӨРЧЛӨЛТИЙГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ



Теле-хичээлийн тухайд: Судалгаанд оролцсон эцэг эхчүүд теле-хичээлийн үед бэрхшээл байсан гээд дараах бэрхшээлүүдийг дурдсан байна.

ХҮСНЭГТ 21. ТЕЛЕ-ХИЧЭЭЛИЙН ҮЕД ЭЦЭГ ЭХЧҮҮДЭД ТУЛГАРСАН БЭРХШЭЭЛ (ЭЦЭГ ЭХЧҮҮДИЙН ХАРИУЛСНААР)

Асуудал	Эзлэх хувь
Теле-хичээл хурдан, ойлгомжгүй байсан	33.8%
Ойлгохгүй зүйлээ хэнээс асуухаа мэдэхгүй хүндрэлтэй байсан	16.9%
Ажилтай учраас теле-хичээлд нь анхаарал тавиагүй	10.3%
Ойлгохгүй зүйл олон, хэцүү байсан	5.9%
Завгүй тул теле-хичээл бараг үзээгүй	5.9%
Хүүхэд залхуурч, үг сонсохгүй байсан	4.4%
Хүүхдийн анхаарал төвлөрөл нь буурч муудсан	1.5%

Теле-хичээлийн үеэр орон нутгийн төлөөлөл болох эцэг эхчүүдийн 90 хувьд, хотын төлөөлөл болох эцэг эхчүүдийн 72 хувьд “бэрхшээл тохиолдож байсан” гэж хариулжээ.


ХҮСНЭГТ 22. ТЕЛЕ ХИЧЭЭЛИЙН ҮЕД ҮҮСЧ БАЙСАН БЭРХШЭЭЛИЙГ ХОТ, ОРОН НУТГААР ХАРЬЦУУЛСАН ҮР ДҮН (ЭЦЭГ ЭХЧҮҮДИЙН ХАРИУЛСНААР)

	Хот	Орон нутаг
Теле хичээл хурдан, ойлгомжгүй байсан	29.4%	42%
Ойлгохгүй зүйл олон, хэцүү байсан	17.6%	16%
Ажилтай учраас теле-хичээлд нь анхаарал тавиагүй	5.9%	18%
Ойлгохгүй зүйлээ хэнээс асуухаа мэдэхгүй хүндрэлтэй байсан	4.7%	8%
Завгүй тул теле-хичээл бараг үзээгүй	5.9%	4%
Хүүхэд залхуурч, үг сонсохгүй байсан	5.9%	2%
Хүүхдийн анхаарал төвлөрөл нь буурч муудсан	2.4%	0%

Эцэг эхчүүдийн 46.3 хувь нь теле-хичээлийн үед бэрхшээл тулгарсан ч тусламж авч байгаагүй, 28.7 хувь нь багшаас тусламж авч байсан, 19.9 хувь нь гэр бүлийнхнээсээ, үлдсэн 3 хувь нь хамаатан садан, ангийнхнаас нь тусламж авч байсан гэжээ. Харин хэнээс туслалцаа авахыг хүсч байсан бэ гэдэг асуултад 46.3 хувь нь багшаас туслалцаа авахыг хүсч байсан гэжээ.


Хүүхдэдээ зарцуулах цаг хугацаа: Эцэг эхчүүдийн 69.9-80 хувь нь теле-хичээлийн үед хүүхдэдээ зарцуулах цаг нэмэгдсэн гэжээ. Харин эцэг эхчүүдийн 2-9.4 хувь нь хүүхдэдээ зарцуулах цагаа нэмэгдсэн эсэхийг мэдэхгүй, 18-21.2 хувь нь “цаг нэмэгдээгүй” буюу “үгүй” гэж хариулсан байна.

ЗУРАГ 39. ЭЦЭГ ЭХЧҮҮДИЙН ХҮҮХДЭДЭЭ ЗАРЦУУЛАХ ЦАГ НЭМЭГДСЭН ЭСЭХИЙГ ХОТ, ОРОН НУТГААР ХАРЬЦУУЛСАН ҮР ДҮН (ЭЦЭГ ЭХИЙН ХАРИУЛСНААР)



Эцэг эхчүүдийн сэтгэл санааны байдал: Сургууль түр хаагдаж хүүхэд нь гэртээ байх үед эцэг эхчүүдийн 47.8 хувь нь урьдын адил тайван байсан, 52.2 хувь нь хэцүү байсан гэж хариулсан байна. Эцэг эхчүүд сэтгэл санаа хэцүү байх гэдэгт хүүхдэдээ санаа зовох, бухимдах, залхах, түгших гэсэн шинжүүдийг багтаасан байна.


ЗУРАГ 40. ХӨЛ ХОРИОНЫ ҮЕ ДЭХ ЭЦЭГ ЭХЧҮҮДИЙН СЭТГЭЛ САНААНЫ БАЙДАЛ (ЭЦЭГ ЭХЧҮҮДИЙН ХАРИУЛСНААР)



Багш нарын сэтгэл санааны байдал

Багш нарын 33 хувь нь хөл хорионы үед цахим хэрэглээний үр чадвараа сайжруулж, шинэ зүйл сурч мэдсэн нь эерэг өөрчлөлт байсан гэжээ. Мэргэжлийн онцлогоос шалтгаалан хөл хорионоос бусад үед өөрийн гэр бүл болон хүүхдэдээ зарцуулах цаг хангалтгүй байдаг байсан бол хөл хорионы үед гэр бүлийнхэнтэйгээ харилцах нь нэмэгдэж, гэр бүлдээ илүү их цаг зарцуулах болсон нь эерэг өөрчлөлт байсан хэмээн 32 хувь нь хариулжээ. Багш нарын 30 хувь нь хөл хорионы үед сэтгэл санаа тайван, амарч чадаж байсан нь сэтгэл зүйд гарсан эерэг өөрчлөлт гэжээ.

ЗУРАГ 41. БАГШ НАРЫН СЭТГЭЛ САНААНЫ БАЙДАЛД ГАРСАН ЗЭРЭГ БА СӨРӨГ ӨӨРЧЛӨЛТҮҮД
(БАГШ НАРЫН ХАРИУЛСНААР)



Багш нарын сэтгэл зүйд гарсан сөрөг өөрчлөлтүүдийн 52 хувийг сурагчдын хичээлийн идэвх, оролцоо болон агуулгыг ойлгож байгаа эсэхтэй холбоотой санаа зовнил эзэлж байна. Теле-хичээл нь багш нарын ажлын ачааллыг нэмэгдүүлж байсан ба хичээл бэлдэх болон сурагчдын даалгаврыг нэг бүрчлэн шалгахад хугацаа их зарцуулдаг бөгөөд үүнээс болж стресстэйг бүхмиддэг гэх мэт сөрөг өөрчлөлт гарсан гэж багш нарын 18 хувь нь үзсэн байна. Багш нарын 16 хувь нь сэтгэл зүйн хувьд айдас, түгшүүртэй байсан хэмээн хариулсан бөгөөд хичээлийн агуулгын хоцрогдол болон хичээлийн идэвх оролцоотой холбоотой санаа зовнил нь цаашлаад айдас, түгшүүр үүсгэх үндэс нь болж байв. Хөл хорионы эхэнд үед багш нарт цахимаар хичээл ордог болчихвол ажлын байргүй болох вий гэсэн түгшүүр үүсч байсан байна. Ажлын ачаалаас шалтгаалан толгой өвдөх, ядрах, нүд өвдөх зэрэг эрүүл мэндийн асуудлууд үүссэн гэж багш нарын 9 хувь хариулсан бол нийгмийн харилцаанд орж чадахгүй, ажлын хамт олон, сурагчидтайгаа уулзаж чадахгүй байснаасаа болж уйдах, ганцаардах зэрэг өөрчлөлт нийт багш нарын 5 хувьд нь гарсан байна.

Нэгдүгээр анги болон төгсөх ангитай багш нарын хувьд санаа зовнил харьцангуй их байна. Тухайлбал:

- Сурагчид теле-хичээлдээ бүрэн хамрагддаггүй, идэвх оролцоо сул байх
- Амьд харилцаа үүсэхгүй, сурагчидтай түлж ажиллах боломжгүй учир сурагчид ойлгож байгаа болов уу гэдэгт санаа зовох. Зөв буруу хийж байгааг нь хэлж өгөх боломжгүй байх
- Сургууль аюулгүй орчин нь болдог байсан зорилтот бүлгийн сурагчдад санаа зовох (гэр бүлийн хүчирхийлэл болон бусад төрлийн хүчирхийлэлд өртөх гэх мэт) зэргийг дурджээ.


"... Ангийнхандаа маш их санаа зовж байна. Зорилтот бүлгийн хүүхэд олон, тэд яаж байгаа бол гэсэн айдас. Тэр хүүхдүүдийн хувьд теле-хичээл үзэх боломжгүй. Аюулгүй байгаа нь л чухал юм даа..."

Багшийн ярилцлагаас

Намар хичээл эхлэхэд сурагчдад тулгамдах хүндрэл бэрхшээл

Сурагчдын хүлээлт: Сурагчдын 91.4 хувь нь есөн сард сургууль дээрээ хичээллэхийг хүсэн хүлээж байна гэж хариулжээ. Ялангуяа нэгдүгээр ангийн сурагчид (эрэгтэй сурагчид 100 хувь, эмэгтэй сурагчдын 85.7 хувь) есөн сард сургуульдаа явахыг хүсэн хүлээж байна.

ЗУРАГ 42. ДҮНД БА АХЛАХ АНГИЙН СУРАГЧДЫН СУРГУУЛЬ, БАГШ, ХИЧЭЭЛД ХАНДАХ ХАНДЛАГА (ХҮҮХДҮҮДИЙН ХАРИУЛСНААР)




Сурагчдын 80 хувь нь теле-хичээлд сөрөг хүлээлттэй байгаа буюу теле-хичээлд дургүй, халширч байгаа бол, 90.5 хувь нь танхимын хичээлд эерэг хандлагатай буюу сургууль дээрээ хичээллэх хүсэлтэй, ангид хичээллэх хүлээлттэй байна.

Сурагчдын 78 хувь нь өөрийн хичээл сурлагадаа сөрөг хандлагатай буюу сурлагаар хоцрогдож байгаа гэсэн санаа зовнилтой байна. Сурагчдын сурлагаар хоцрогдож байгаа гэсэн санаа зовнил нь тэд гэнэтийн, сургалтын шинэ хэлбэрт дасан зохицох, өмнөхөөсөө илүү бие даах, ганцаараа хичээллэх шаардлагатай болсон, мөн теле-хичээл нь сурагчдын дассан сурах арга барилтай нийцэхгүй, тэдний онцлог, хэрэгцээг хангаж чадахгүй байгаа зэрэг нөхцөл, шалтгаанаас үүдэлтэй байна. Тухайлбал, сурагчдад багштайгаа шууд харилцах, чиглүүлэг авах, ойлгохгүй байгаа зүйлээ тухай бүрт нь асууж лавлах боломжгүй, ангийн хамт олонтойгоо шууд харилцах, бие биеэсээ суралцах боломжгүй байх, цаашлаад хичээлээ ойлгохгүй байгаагаас үүдэн дур сонирхолгүй болох, зөнд нь хаях, нийтлэг биш боловч цөөн тооны сурагчдын хувьд анги дэвшин суралцахдаа итгэлгүй болох, дараагийн шатны сургуульд элсэн орох шалгалтад тэнцэхгүй байх вий гэсэн байнгын санаа зовнил үүсэх зэрэг асуудлууд тулгарч байна.

Түүнчлэн сурагчдын 44.1 хувь нь сургууль болон багш нартаа эерэг хандлагатай байгаа ба орон нутгийн сурагчдыг хотын сурагчидтай харьцуулбал илүү эерэг хандлагатай байна. Энэ нь хот ба орон нутагт багш, сурагчийн тооны харьцаа ялгаатай буюу орон нутагт нэг багш харьцангуй цөөн сурагчидтай ажилладаг, ганцаарчлан харилцах боломж илүү байгаагаар холбоотой байж болно.

Эцэг эхчүүдийн хүлээлт: Сургууль дээр хичээллэх (танхимын сургалт эхлэх)-д тулгарч болох хүндрэл бэрхшээлүүдийг эцэг эхчүүд доорх байдлаар үнэлж байна.


ЗУРАГ 43. ЭЦЭГ ЭХЧҮҮДИЙН ХИЧЭЭЛИЙН ШИНЭ ЖИЛИЙН ХҮЛЭЭЛТ



Есдүгээр сарын нэгнээс сургууль дээр хичээллэхэд тулгарч болох хүндрэл бэрхшээлүүдийг багш нар үнэлсэн байдал

Багш нараас намар хичээл эхлэхэд сурагчдад тулгарч болох хүндрэл бэрхшээлийн тухай асуухад дийлэнх нь сурлагын болон агуулгын хоцрогдол, дасан зохицлыг онцолж байна.

ЗУРАГ 44. БАГШ НАР ХИЧЭЭЛИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХЭЛБЭРИЙГ ҮНЭЛЖ БҮЙ БАЙДАЛ



Судалгаанд оролцсон багш нарын 71.4 хувь нь хичээл эхлэхэд сурагчдад тулгарах хамгийн тулгамдсан бэрхшээл бол сурлагын болон агуулгын хоцрогдол гэж үзэж байна. Сурагчдын теле-хичээлийн оролцоо болон хичээлийн агуулгыг ойлгох нь муу байсан учир өмнөх ангийн мэдлэгийг дахин давтаж бататгасны дараа, дараагийн агуулгыг үзэх хэрэгтэй гээд, сурагч бүрийн мэдлэгийн түвшин харилцан адилгүй болсон гэж үзэж байна. Багш нар сурагчдын агуулгын хоцрогдлыг арилгах арга замыг эхний 4-5 долоо хоногт бататгах болон давтлага хичээл орох, үүний дараа шинэ хичээлийн жилийн хөтөлбөрийг үзэх хэрэгтэй гэжээ. Сурагчдад тулгарч болох дараагийн бэрхшээлийг “дасан зохицох асуудал” гэж нийт багш нарын 16 хувь нь үзэж байна. Зуны амралтын дараа хичээл эхлэхэд сурагчдад тодорхой хэмжээний

дасан зохицох хугацаа хэрэгтэй байдаг бөгөөд 7 сар гаруй хугацаанд нийгмийн идэвхтэй харилцаанд оролцоогүй сурагчдын тухайд анхаарал төвлөрөлт сул, ядрах, идэвхгүй байх, төвлөрч сууж чадахгүй байх, зан ааш өөрчлөгдөх, харилцааны зөрчил үүсэх зэрэг асуудал үүсч болзошгүй бөгөөд эдгээрийг шийдэхэд ангийн багш болон сургуулийн нийгмийн ажилтны оролцоо чухал гэж багш нар үзэж байна. Түүнчлэн нийт багш нарын 13 хувь нь өвчин тархах эрсдэл нь 9 дүгээр сард хичээл эхлэхэд сурагчдад тулгарч магадгүй хүндрэл, бэрхшээлийн нэг хэмээн үзэж байна. Анги танхимын хүрэлцээ, сурагчдын бөөгнөрөл гэх мэт зүйлс эрсдэл үүсгэнэ гэж багш нар үзэж байна. Ариун цэвэр сайн сахиж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авснаар дээрх асуудлыг шийдэж болно гэж тэд үзэж байна.

“... Үл ойлголцол! Би декритээ авчихаад 1 жилийн дараа ирэхэд танихгүй хүүхэд шиг л болсон байсан ...”

Багшийн ярилцлагаас

Багш нарын 94 хувь нь теле-хичээл үргэлжлэх тохиолдолд сурагчдад тулгарах хүндрэл, бэрхшээл нь “хичээлийн идэвх оролцоо болон хоцрогдол” хэмээн үзэж байна. Мөн цаашлаад хичээлдээ удаан явахгүй, нийгмийн харилцаанд оролцох нь хязгаарлагдмал байсны улмаас харилцааны асуудлууд тулгарч магадгүй хэмээн багш нарын 6 хувь нь үзжээ.

Багш нар теле-хичээлийн үед сурагчдын хичээлийн идэвх оролцоо сул байсан нь дараах шалтгаантай гэж үзэж байна. Үүнд:

- Сурагч бүр теле-хичээл үзэх орчин, боломж байхгүй
- Ухаалаг утас, интернет, датагүй учир даалгавраа илгээх боломжгүй
- Хичээлийн хугацаа богино учир ухрааж үзэх боломжгүй
- Хөдөө явах, гэрийнхээ ажилд туслах
- Дүүгээ харах
- Эцэг эхийн хараа хяналт сул, анхаарал халамж муу
- Хичээлийн агуулгыг ойлгоогүйн улмаас теле-хичээл хийх сонирхол нь буурах
- Амьд харилцаа байхгүй, ойлгохгүй зүйлсээ асуух, зааварчилгаа авах боломжгүй туслах хүнгүй
- Сурах сонирхол бага
- Теле- хичээлээс уйдах гэх мэт.

Багш нар дээр дурдсан шалтгаануудын улмаас сурагчдын теле-хичээлийн ирц, оролцоо хангалтгүй байх, энэ нь улмаар сурагчид хичээлийн агуулгаас хоцрох шалтгаан болдог гэжээ.

ДҮГНЭЛТ

КОВИД-19 цар тахлын үеийн хөл хорио нь ерөнхий боловсролын сургуулийн болон цэцэрлэгийн хүүхдүүд тэдний эцэг эх, багш нарын сэтгэл зүйд хэрхэн нөлөөлж, ямар асуудал бэрхшээл байгааг дараах байдлаар нэгтгэн дүгнэж байна. Үүнд:

1. ХҮҮХЭД


Судалгаанд оролцсон нийт сурагчдын 56.2 хувьд дасан зохицох чадвар “сул” байгаа нь ээнэгшлийн түгшүүр илэрч байгаатай холбоотой гэж үзэж байна. Дасан зохицох чадвар сул байгаа нь хүүхдийн нийгэм-сэтгэл хөдлөл, нийгэм-сэтгэл зүйн хүчин зүйлүүдтэй уялдаатай.

Нийгэм-сэтгэл хөдлөлд сурагчдын харилцаа, сэтгэлийн хөдөлгөөн, мэдрэмжийг судлахад, хөл хорионы үед гурван сурагч тутмын нэгний гэр бүлийн харилцаа “тааруу”, гурван сурагч тутмын нэгнийх нь найз нөхдийн харилцаа “тааруу” гэсэн байна. Энэ нь сурагчдын сэтгэл санаанд сөргөөр нөлөөлж ганцаардах, уйтгарлах, бүхимдалтай болох зэрэг сөрөг үр дагаврууд үүсэхэд хүргэсэн байна. Сургуулийн дунд ангийн буюу 6-13 насны сурагчдад стресс бүхимдал хэвийн үзүүлэлтээс өндөр бөгөөд сурагчдын дийлэнх нь КОВИД-19 цар тахлаас, сурлагаар хоцрогдохоос айж байгаа тул айдсыг багасгахад дэмжлэг туслалцаа үзүүлэх шаардлагатай байна. Мөн сурлагаар хоцрогдох, КОВИД-19 вирус халдах, өвчлөх, хичээл эхлэхэд шалгалт өгөх, сургууль дээрээ эргэн очихдоо зожиг болсон байх, анги улирахаас айх, санаа зовних зэрэг байдал сурагчдын дунд нийтлэг байна.

Хүүхдүүдийн нийгэм-сэтгэл зүйн асуудлын хүрээнд сургуульдаа хандах хандлага, зан үйлийн өөрчлөлтийг шинжлэн үзэхэд ЕБС-ийн сурагчдын танхимын хичээлд хандах хандлага эерэг, багш, найз нөхдөө санасан төдийгүй тэд теле-хичээлээс залхаж халширсан байна. Танхимын хичээлд эерэг хандлагатай байх нөхцөл нь ангийн найз нөхөдтэйгөө хамт хичээллэхэд голлож байгаа бол теле-хичээлдээ сөрөг хандлагатай байх шалтгаан нь теле-хичээл хурдан гарч өнгөрдөг, ойлгоогүй зүйлээ асуух боломжгүй, амьд харилцаа байхгүй зэрэг бэрхшээлүүд байна. Мөн сурагчид өөрсдийгөө хөл хорионы үед найз нөхдөөсөө хөндийрсөн, сурлагаар хоцрогдсон гэж үзэж байна. Хөл хорионы хугацаанд хүүхдүүдийн амьдралын дэглэм өөрчлөгдсөн байна. Жишээлбэл, орой унтаж хожуу босох, их идэх, хөдөлгөөний дутагдалд орох төдийгүй цахим хэрэглээ нь нэмэгдсэн байна.

Сургуулийн өмнөх насны хоёр хүүхэд тутмын нэгд нь хөл хорионоос үүдэлтэй харилцаа, сэтгэлийн хөдөлгөөн, зан үйлийн өөрчлөлтүүд гарч хэт дураараа, өөрийнхөөрөө зүтгэж эрхлэх, түрэмгийлэх зэрэг шинжүүд нийтлэг илрэх болжээ. Түүнчлэн сургуулийн өмнөх насны хүүхдүүдийн гар утасны хэрэглээ нэмэгдэж, зожгирох байдал ажиглагдаж байна. Хүүхдүүд цэцэрлэгтээ явмаар байгаагаар илэрхийлэх болж, нөгөө талдаа өмнө цэцэрлэгтээ сурсан зүйлсээ мартаж зэрэг нь нийтлэг байна.

ЗУРАГ 45. СУДАЛГААНЫ ҮР ДҮНГ НЭГТГЭСЭН ЗУРАГЛАЛ



Дээрх үр дүнгээс харахад хөл хорионы үед сурагчдын харилцаа, сэтгэлийн хөдөлгөөн, зан үйлд гарч буй асуудлууд нь цаашид удаан үргэлжилбэл тэдний бие махбод, танин мэдэхүй, нийгэмшихүй болоод бие хүний хөгжилд сөргөөр нөлөөлж болзошгүй байна.

Сурагчдын дасан зохицох чадвар сул, түүнийг илтгэх гол хүчин зүйл болох харилцаанд бэрхшээл үүсч байгаа нь сэтгэлийн хөдөлгөөн, зан үйлийн асуудлуудыг дагуулж байна. Мөн дасан зохицох чадварт нөлөөлөх ээнэгшлийн түгшүүр илэрч байна. Эдгээр нь удаан хугацаагаар үргэлжилбэл буруу зан үйлд автах, донтох, бусдын нөлөөнд орох, сурлагаар хоцрох, сурах сэдэлгүй болох, танин мэдэхүйн бэрхшээлүүд үүсэх, сургуулиас завсардах, сургуулиа орхих эрсдэлтэй.

2. ЭЦЭГ ЭХ

Судалгаанд оролцсон эцэг эхчүүдийн талаас илүү хувь нь хөл хорио тогтоож хүүхдүүд гэртээ байх болсон нь (i) хүүхдийнхээ хичээлд санаа зовох, (ii) гэр бүлийн болон хүүхэд эцэг эхийн харилцааны асуудал, өрхийн орлого буурсан, ажилгүй болсон, өрхийн зарлага нэмэгдсэн зэргээс болж бухимдах, (iii) удаан хугацаагаар хүүхэдтэйгээ хамт байхаас залхах, (iv) КОВИД 19-өөс, ирээдүйд үүсч болох эрсдэлээс түгших зэргээр сэтгэл санааны хувьд тогтворгүй, хэцүү төвөгтэй байдалд байна. Хөл хорионы үед хүүхдүүд гэртээ байнга байж, эцэг эхчүүд хүүхдэдээ их хугацаа зарцуулж байгаа нь нэг талаас бие биенийгээ ойлгох, илүү таньж мэдэх зэрэг эерэг нөлөөтэй байсан хэдий ч гэр бүлийн зөрчил маргаан нэмэгдэх, гэр бүлийн харилцаанд асуудал бэрхшээл үүсэх зэрэг сөрөг нөлөө байсан байна. Эдгээр сөрөг нөлөөг дунд, ахлах ангийн сурагчид өөртөө илүү хүндээр тусгаж байна. Түүнчлэн хөл хорио

тогтоосон, сургууль хаасан үеийн хүүхдийн сэтгэл зүйд гарч буй олон өөрчлөлтийг эцэг эхчүүд хүүхдүүдээс ялгаатай үнэлсэн. Тухайлбал, хүүхдийн ганцаардал, стресс бухимдал, харилцаа зэргийг эцэг эхчүүд хүүхдүүдээс харьцангуй бага гэж дүгнэсэн нь эцэг эхчүүд хүүхдийнхээ сэтгэл зүйн байдлыг харьцангуй хөнгөн гэж үнэлж байна.

3. БАГШ

Багш нар хөл хорионы үед цахим хэрэглээний үр чадвараа сайжруулсан, шинэ зүйл сурч мэдсэн, гэр бүлдээ илүү цаг зарцуулж чадсан, сэтгэл санаа илүү тайван байх болсон зэрэг эерэг давуу талууд байгаа хэдий ч судалгаанд оролцсон багш нарын талаас илүү хувь нь сурагчдын хичээлийн идэвх, оролцоо болон агуулгыг ойлгож байгаа эсэхэд санаа зовниж байна. Үүнээс гадна судалгаанд оролцсон дийлэнх багш нар сурлагын болон агуулгын хоцрогдол, үүнээс үүдэх санаа зовнил, айдас, бухимдал, мөн дасан зохицлыг намар хичээл эхлэхэд сурагчдад тулгарч болох хүндрэл бэрхшээл хэмээн онцолж байна.

ЗӨВЛӨМЖ

БШУЯ, СУРГУУЛИЙН ЗАХИРГАА, БАГШ НАРЫН НЭН ТЭРГҮҮНД ХИЙХ АЖЛУУД

- Сурагчдын шалгалтаас айх айдсыг багасгахын тулд шинэ хичээлийн жилийн эхэнд авах түвшин тогтоох шалгалт нь “сурагчдын хичээлийн хоцрогдлыг нөхөх” зорилготой болохыг сурагчдад тайлбарлан ойлгуулах
- КОВИД-19-өөс айж байгаа хүүхдийн айдсыг багасгахын тулд хүүхдийн нас, сэтгэл зүйн онцлогт тохирсон мэдээллийг олон төрөл, хэлбэр (видео, зурагт хуудас, хүүхэлдэйн кино гэх зэрэг)-ээр хүргэх
- Сурагчдын теле-хичээлээс халшрах байдлыг арилгаж, сурах сэдлийг нэмэгдүүлэхийн тулд теле-хичээлийн арга зүйг сурагч нэг бүрт хүртээмжтэй байдлаар өөрчлөн сайжруулах, шинэ технологи, шинжлэх ухааны дэвшлийг зохистой байдлаар нэвтрүүлэн түрших
- Теле-хичээл заах багшийг сонгох, бэлтгэх ажлыг өмнөх түршлагад тулгуурлан сайжруулах. Тухайлбал, нэг төрлийн хичээлийг нэг ангид нэг багш дагнан заах зэрэг өөрчлөлт, сайжруулалтыг хийх
- Теле-хичээлийг давтаж, нөхөн үзэх арга замуудыг өргөжүүлэх, боломжит бүх хэлбэр (телевиз, ФМ/FM, радио, фэйсбүүк/facebook, зурагт хуудас гэх зэрэг)-ээр, олон давтамжтайгаар сурагчдад болон эцэг эхчүүдэд таниулах
- Сургуулийн нийгмийн ажилтан, сургуулийн эмч, ангийн багшийн хамтын ажиллагааг дэмжин сайжруулах. Сэтгэл зүйн чиглэлээр их, дээд сургуулийн сэтгэл судлалын тэнхим, сэтгэл зүйн зөвлөгөө, оношилгоо хийдэг байгууллага, мэргэжлийн хүмүүстэй хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлэх
- Сургууль дээр нөхцөл бүрдсэн тохиолдолд сурагчдад “сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх бүлэг” байгуулж ажиллах. Багийн бүрэлдэхүүнд сургуулийн нийгмийн ажилтан, эмч, сургалтын менежер, сурагч, багшийн төлөөлөл байж болно.

ЦААШИД ХИЙХ АЖЛУУД

Судалгааны үр дүнд илэрсэн дараах сэтгэл зүйн асуудлуудаар сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх мэргэшсэн баг ажиллуулж тогтмолжуулах нь зүйтэй. Сургууль дээр ажиллах сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх багт сургуулийн эмч, нийгмийн ажилтан, багш, сурагчийн төлөөлөл болон мэргэжлийн сэтгэл зүйч байна. Боломж бүрдсэн орон нутаг, сургуулийн сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх багт “явуулын буюу дундын” мэргэжлийн сэтгэл зүйч ажиллуулж болно. Сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх баг нь их, дээд сургуулийн мэргэжлийн тэнхим, сэтгэл зүйн зөвлөгөө, оношилгоо хийдэг байгууллагуудтай хамтран ажиллаж болно.

Сургуулийн сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх багийн хийж гүйцэтгэх ажлын жагсаалтад дараах зүйлс багтаж болно. Үүнд:

- Дасан зохицох чадварыг нэмэгдүүлэх
- Сэтгэл хөдлөлийн тогтвортой холбоо тогтоох
- Сэтгэлийн хөдөлгөөнийг зохицуулах
- Сурах сэдэл, тэмүүллийг нэмэгдүүлэх
- Стрессийг даван туулах чадварыг нэмэгдүүлэх

- Харилцааны асуудлыг шийдвэрлэх
- Асуудлыг бодитоор харах, өөрийн бурууг хүлээн зөвшөөрөх чадварт суралцуулах

Сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх багийн үүрэг, үйл ажиллагааны чиглэл:

- Сэтгэл зүйн оношилгоо хийх
- Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх
- Сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх сургалт зохион байгуулах
- Сурагчдын дунд байгаа сэтгэл зүйн асуудлыг тандан илрүүлэх судалгаа хийх
- Сэтгэл зүйн талаарх мэдлэг, мэдээлэл түгээх

Хэрэв дахин сургууль хаагдвал оролцогч талуудын зүгээс анхаарах шаардлагатай дараах асуудлууд байна. Үүнд:

- Сэтгэл зүйн баг онлайн болон утсаар сурагчид, багш, эцэг эхчүүдэд дэмжлэг үзүүлэх
- Багш нар сурагчидтай байнгын эргэх холбоотой ажиллах
- Эцэг эхчүүд хүүхдийнхээ сэтгэл зүйн байдалд анхаарах.

НОМ ЗҮЙ

- Andrew, A., Catta, S., Costas-Dias, M., Farquharson, C., Kraftman, L., Krutikova, S., . . . Sevilla, A. (2020). Learning during the lockdown: real-time data on children's experiences during home learning. IFS Briefing Note BN288. London: Institute for Fiscal Studies.
- Bol, T. (2020). Inequality in homeschooling during the Corona crisis in the Netherlands. First results from the LISS panel. In Working Paper, April 30 2020. University of Amsterdam.
- Brooks, S. K., Webster, R. K., Smith, L. E., Woodland, L., Wessely, S., Greenberg, N., & Rubin, G. J. (2020 оны 2 26). The psychological impact of quarantine and how to reduce it: rapid review of the evidence. *Lancet*(395), 912-920.
- Clerici, C., Massimino, M., & Ferrari, A. (2020 оны 6 5). On the clinical psychologist's role in the time of COVID-19, with particular reference to experience gained in pediatric oncology. *Psychooncology*.
- Darlington, A.-S. E., Morgan, J. E., Wagland, R., Sodergren, S., Culliford, D., Gamble, A., & Phillips, B. (2020). COVID-19 and children with cancer: Parents' experiences, anxieties, and support needs. medRxiv.
- DiGiovanni, C., Conley, J., Chiu, D., & Zaborski, J. (2004). Factors influencing compliance with quarantine in Toronto during the 2003 SARS outbreak. *Biosecur Bioterror*(2), 265-272.
- Fegert, J., Vitiello, B., Plener, P., & Clemens, V. (2020). Challenges and Burden of the Coronavirus 2019 (COVID-19) Pandemic for Child and Adolescent Mental Health: A Narrative Review to Highlight Clinical and Research Needs in the Acute Phase and the Long Return to Normality. *Adolescent Psychiatry and Mental Health*(20), 14-20.
- Grechyna, D. (2020 оны 4 7). Health threats associated with children lockdown in Spain during COVID-19. Available at SSRN: <https://ssrn.com/abstract=3567670>.
- Hawryluck, L., Gold, W., Robinson, S., Pogorski, S., Galea, S., & R, S. (2004). SARS control and psychological effects of quarantine, Toronto, Canada. *Emerg Infect Dis*, 10, 1206-1212.
- INEE. (2020). WEIGHING UP THE RISKS: SCHOOL CLOSURE AND REOPENING UNDER COVID-19 – WHEN, WHY, AND WHAT IMPACTS? NY: Inter-agency Network for Education in Emergencies (INEE).
- Jæger, M. M., & Blaabæk, E. H. (2020). Inequality in Learning Opportunities during Covid-19: Evidence from Library Takeout. *Research in Social Stratification and Mobility* .
- Lee, S., Chan, L., Chau, A., Kwok, K., & Kleinman, A. (2005). The experience of SARS-related stigma at Amoy Gardens. *Soc Sci Med*(61), 2038-2046.
- Marjanovic, Z., Greenglass, E., & Coffey, S. (2007). The relevance of psychosocial variables and working conditions in predicting nurses' coping strategies during the SARS crisis: an online questionnaire survey. *Int J Nurs Stud* (44), 991-998.
- Maunder, R., Hunter, J., & Vincent, L. (2003). The immediate psychological and occupational impact of the 2003 SARS outbreak in a teaching hospital. *CMAJ*(168), 1245-1251.
- Mihashi, M., Otsubo, Y., Yinjuan, X., Nagatomi, K., Hoshiko, M., & Ishitake, T. (2009). Predictive

- factors of psychological disorder development during recovery following SARS outbreak. *Health Psychology*, 28, 91-100.
- Reynolds, D., Garay, R., Deamond, S., Moran, M., Gold, W., & Styra, R. (2008). Understanding, compliance and psychological impact of the SARS quarantine experience. *Epidemiol Infect*(136), 997-1007.
- Saurabh, K., & Ranjan, S. (2020). Compliance and Psychological Impact of Quarantine in Children and Adolescents due to Covid-19 Pandemic. *Indian Journal Pediatrics*(29), 1-5.
- Sprang, G., & Silman, M. (2013). Posttraumatic stress disorder in parents and youth after health-related disasters. *Disaster Med Public Health Prep*, 7, 105-110.
- World Bank. (2020). SIMULATING THE POTENTIAL IMPACTS OF COVID-19 SCHOOL CLOSURES ON SCHOOLING AND LEARNING OUTCOMES: A SET OF GLOBAL ESTIMATES. World Bank Group.
- Yoon, M., Kim, S., Ko, H., & Lee, M. (2016). System effectiveness of detection, brief intervention and refer to treatment for the people with posttraumatic emotional distress by MERS: a case report of communitybased proactive intervention in South Korea. *Int J Ment Health Syst*(10), 51.
- НҮБ. (2020). Бодлогын хураангуй, Боловсрол: КОВИД-19 цар тахлын үед болон түүний дараа. НҮБ.
- НҮБ-ын Хүүхдийн Сан. (2020). Онцгой байдлын үеийн теле хичээл, түүний үрдүн, тохиромжтой байдал. Улаанбаатар.
- Нээлттэй Нийгэм Форум. (2020). Ковид-19 ба хөгжлийн бэрхшээл. Улаанбаатар: Нээлттэй Нийгэм Форум.

ХАВСРАЛТ

ХӨЛ ХОРИОНЫ ҮЕД ХҮҮХДЭД СЭТГЭЛ ЗҮЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ

Нэг. Хүүхдэд зориулсан зөвлөмж

Өөрийн эрүүл мэндийг хамгаалах, санаа зовох байдлаа багасгахын тулд:

- КОВИД-19-өөс урьдчилан сэргийлэх аргууд нь үр дүнтэй гэдгийг санаж сайтар хэрэгжүүлэх
- Айх, бухимдах, санаа зовох зэрэг мэдрэмжүүдээ эцэг эх, багшдаа ярих, хуваалцах
- Хичээл, даалгавраа дараа гэж хойш тавилгүйгээр цаг тухайд нь хийх

Хичээл, сурлагадаа амжилт гаргахын тулд:

- Хичээлийн хоцрогдлоо хэр хэмжээнд байгааг таньж мэдэх, хэрэв бие даан өөрийн нөхцөл байдлаа үнэлж дүгнэх боломжгүй бол багшаасаа тусламж авах
- Багштайгаа ярилцах, сурлагаа ахиулах, хоцрогдлыг нөхөх талаар төлөвлөгөө гаргах
- Ойлгохгүй, чадахгүй байгаа зүйлсээ ангийн найз нөхөд болон багш нараасаа асууж, давтах, бэхшээлийг хэн нэгэнтэй хуваалцах, бусдаас дэмжлэг авах
- Гэрийн даалгавар хийх болон гэрийн ажлаа хийх цагаа эцэг эх, гэр бүлийнхэнтэйгээ хамт гаргах, өдрийн дэглэм гаргаж мөрдөх
- Теле хичээл нөхөж үзэх боломжтой цахим эх сурвалжуудын жагсаалтыг мэддэг болох
- Сурлагын амжилтаа ахиулах цаг хугацаа, хичээл зүтгэл хэрэгтэй гэдгийг санаж өдөр бүрийн мэдсэн, чаддаг болсон зүйлсээ тэмдэглэдэг байх

Дасан зохицох чадвараа сайжруулахын тулд:

- Тулгарсан ямар ч асуудлыг даван туулах бөгөөд үүнд цаг хугацаа хэрэгтэй гэдгийг санах
- Эцэг эх, найз нөхөдтэйгээ өөрийн бодол, мэдрэмжийнхээ тухай ярилцах
- Бусадтай ярилцах үедээ тэдний нүүрний хувиралыг ажиглах
- Багийн ажил, анги нийтийн үйл ажиллагаанд оролцох, санаачлах, багаар ажиллах, хамтран тоглох
- Өгүүлэл, тууж зэрэг өөрийн сонирхсон ном зохиолоо унших, уншсан зүйлээ бусдад ярих, хуваалцах

Хоёр. Эцэг эхэд зориулсан зөвлөмж

Хүүхдийн хичээлд санаа зовох байдлаа багасгахын тулд:

- Эхлээд санаа зовж байгаа шалтгаануудыг эрэмбэлэн бичих
- Эрэмбэлсэн шалтгаануудыг бууруулах, арилгахын тулд хүүхэдтэйгээ хичээлтэй холбоотой тохиролцоонууд хийх, төлөвлөгөө гаргах. Тухайлбал: хичээл хийх цаг, гэрийн ажил хийх цагийн хуваарийг тогтоох гэх мэт.
- Хүүхдийнхээ багштай холбоотой байж, хүүхдийнхээ ямар түвшинд байгаа, ямар хичээл дээр анхаарах ёстой зэргийг тодруулах
- Хүүхдийнхээ зан үйл, өөрчлөлтийг багштай хуваалцах, тулгарсан бэрхшээлийг хамтран шийдэх арга барилд суралцах, түүнийгээ ашиглах
- Мэргэжлийн багш нараас зөвлөгөө авах

- Хүүхдэд болон өөрт тань сэтгэл зүйн асуудал байгаа бол мэргэжлийн сэтгэл зүйчээс тусламж дэмжлэг авах

Гэр бүлийн болон хүүхэд-эцэг эхийн харилцааны зөрчил, асуудлыг багасгахын тулд:

- Харилцааны асуудал, бэрхшээлүүдийг жагсаан бичих
- Бэрхшээлийн шалтгааныг гэр бүлийнхэнтэйгээ, хүүхэдтэйгээ ярилцах
- Шалтгааныг арилгахын тулд эцэг эхийн болон хүүхдийн зүгээс хийх зүйлсийг тодруулах, ярилцах, тохиролцох
- Гэрийн ажил, үүргийн хуваарь гаргах
- Хүүхдэдээ болон гэр бүлийн бусад гишүүнд уурлах, бухимдах тохиолдлын 2-3-т нь эвээр, тайвнаар хэлэхийг хичээх
- Гэр бүлийн гишүүд бие биендээ уурлах, бухимдах тохиолдолд эвээр хэлэх, даалгавар өгөх, хэрвээ даалгаврыг биелүүлээгүй бол ямар нэгэн байдлаар хариуцлага ногдуулах
- Хүүхдэдээ байнга үгэлж яншихгүй байх. Өдөрт тодорхой цаг хугацаанд шаардлага тавих
- Тоглох зэрэг хүүхдийнхээ хийх дуртай зүйлд нь цаг гаргах, боломж олгох

Хүүхдийнхээ шалгалтаас айх айдсыг багасгахын тулд:

- Хүүхэдтэйгээ өмнөх хичээлийн жилийн сурлагын талаар уурлаж бухимдахгүй тайван ярилцах
- Хүүхэдтэйгээ хамтран хичээл сурлагаа ахиулах, хоцрогдлыг нөхөх талаар ярилцан, төлөвлөгөө гаргах
- Хүүхдийнхээ бага ч гэсэн амжилт бүрийг урамшуулах
- Үргэлж биш боловч КОВИД-19-ийн талаар хүүхдэдээ тайлбарлах, эрүүл ахуйн эерэг дадал зуршлыг тайлбарлах, үлгэрлэх

Хүүхдийнхээ дасан зохицох чадварыг сайжруулахын тулд:

- Хүүхэдтэйгээ инээмсэглэн харилцах, өөрт нь аав ээж нь дуртай, өөрийг нь төвөгшөөхгүй байна гэдгийг мэдрүүлэх
- Ганцаараа бие даан хийх ажлаас илүүтэйгээр бусадтай хамтрах ажил хийлгэх
- Ингэснээр бусадтай харилцах боломжийг бий болгох
- Хүүхдийг найзтайгаа тоглох, ярилцах, хичээлээ хамтран хийх боломжоор хангах, орчныг бүрдүүлэх
- Өгүүлэл, тууж зэрэг өөрийнх нь сонирхолтой ном зохиол уншуулах, нөхцөлийг бүрдүүлэх
- Бие даан шийдвэр гаргахыг дэмжих
- Хүүхдээ урамшуулах
- Хүүхэдтэйгээ ирээдүйн амьдралын талаар, ирээдүйн зорилго, төлөвлөгөөний талаар ярилцах, төлөвлөх
- Орой бүр хүүхэдтэйгээ өдөр болсон зүйлийн талаар ярилцахыг хичээх, юуг буруу хийсэн, юуг зөв хийсэн талаар ярилцах

Гурав. Багшид зориулсан зөвлөмж

Сурагчдын дасан зохицох чадварыг сайжруулахын тулд:

- Сурагчдын шалгалтаас айх айдсыг багасгахын тулд шинэ хичээлийн жилийн эхэнд авах түвшин тогтоох шалгалтын зорилгыг сурагчдад тайлбарлан ойлгуулах
- Инээмсэглэж харилцах, өөрт нь хүмүүс дуртай, өөрийг нь төвөгшөөхгүй байна гэдгийг мэдрүүлэх
- Ганцаараа бие даан хийх даалгавраас илүүтэйгээр багаар ажиллах даалгавар өгөх, бусадтай харилцах хамтрахыг санал болгох
- Өгүүлэл, тууж зэрэг өөрийнх нь сонирхолтой ном, зохиол унших даалгавар өгөх, үйл ажиллагааг зохион байгуулах
- Зоригтой байх, шийдвэр гаргах, хариуцлагатай байх үйл ажиллагаануудад оролцуулах – багаар ажиллуулах
- Сурагчдыг магтах, урамшуулах
- КОВИД-19-ийн нөхцөл байдлын талаар тайлбарлах, анги хамт олноороо хэцүү, бэрхшээлтэй байдлыг хэрхэн даван туулах талаар ярилцах, хамтын шийдвэр гаргах

Сурагчдын айдас, санаа зовинолыг багасгахын тулд:

- КОВИД-19-өөс сэргийлэх аргууд үр дүнтэй болох, хувь хүний үйлдэл чухал гэдгийг тайлбарлах, үлгэрлэх
- Сурагчидтай тайван, хүлээцтэй байх
- Сурагчдын айдас, санаа зовинолыг анхааралтай сонсох, шийдэх арга санал болгох (багаар хичээлээ давтах, хамтран ажиллах баг зэргийг санал болгох)

Сурагчдын бүхимдлыг багасгахын тулд:

- Сөрөг сэтгэл хөдлөлөө ойлгох хугацаа олгох
- Эцэг эх, асран хамгаалагчдыг хүүхэддээ хангалттай цаг гаргахыг зааж зөвлөх
- Хичээлийн явцад тайван, хүлээцтэй байх
- Хичээлийн завсарлагаанаар хөдөлгөөнт дасгал хийх
- Орой унтахаас нэг цагийн өмнө гар утас, телевизээ унтрааж, өдөрт 8-11 цаг унтахыг сануулах
- Сурагчдад хичээлээ хийхэд тохиромжтой нөхцөл, цагийг төлөвлөхөд туслах
- Стрессийг багасгах 1 ба 5 минутын аргын жагсаалт гаргуулах (гүнзгий амьсгаа авах, гадаа гарч алхах, аяга угаах зэрэг)

Сурагчдын ганцаардлыг багасгахын тулд:

- Эцэг эхийн анхаарал халамж багатай, бусдад гадуурхагдаж болзошгүй, өөртөө итгэл муутай, өөрийн үнэлэмж доогуур, бие махбодын хувьд бусдаас ялгаатай хүүхдүүдийг ажиглаж анхаарч байх
- Шаардлагатай тохиолдолд сурагчтайгаа ганцаарчлан ярилцах
- Анги хамт олныг нэгтгэж нягтруулах, хүүхдүүдийн найз нөхөрлөлийн холбоог дэмжих үйл ажиллагааг зохион байгуулах
- Биеийн хөгжлийг дэмжих идэвхтэй хөдөлгөөн, үйл ажиллагааг санал болгох, үлгэрлэх

СУРГУУЛИЙН СЭТГЭЛ ЗҮЙН ДЭМЖИХ БАГИЙН АЖЛЫН УДИРДАМЖ

Үйл ажиллагааны үндсэн чиглэл:

- Сэтгэл зүйн боловсрол олгох
- Сэтгэл зүйн урьдчилан сэргийлэх анхааруулга, санамж
- Сэтгэл зүйн оношилгоо, үнэлгээ
- Хөгжүүлэх болон засан залруулгын ажлууд
- Зөвлөгөө, зөвлөмжүүд зэрэг болно.

Дэмжлэг үзүүлэх багийн сургууль дээр ажиллах хугацаа:

14 хоногт нэгээс доошгүй удаа очиж 2-4 цаг ажиллана. Дэмжлэг үзүүлэх баг тухайн сургууль, зорилтот бүлэгт зориулсан төлөвлөгөө гаргана.

ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАГВАР

№	Үйл ажиллагааны төрөл	Хугацаа	Биелэлт	Тайлбар
1.	Сургуулийн онцлог, үйл ажиллагаатай танилцах зохион байгуулалтын ажил – Тухайн сургуулийн онцлог, дотоод дэг журам, сурагчдад чиглэсэн ажлын төлөвлөгөө зэрэг зохион байгуулалттай танилцах – Тухайн сургуулийн онцлогт тохирсон ажлын төлөвлөгөөг гаргах			
2.	Сэтгэл зүйн боловсрол олгох ажил – Лекц унших, сургалт зохион байгуулах – Ханын сонин, сэтгүүл гаргах – Уулзалт, ярилцлага зохион байгуулах			
3.	Оношилгоо – Сурагчдын онцлогт тохирсон оношилгооны аргуудыг сонгон авч оношилгоо хийх			
4.	Хөгжил залруулгын ганцаарчилсан ажил – Сурагчдын асуудал, бэрхшээл, онцлогт тохирсон дасгал ажлуудыг зохион байгуулах			
5.	Хөгжил залруулгын бүлгийн ажил – Тухайн бүлгийн онцлогт тохирсон бүлгийн дасгал ажлуудыг зохион байгуулах			
6.	Зөвлөгөө – Ганцаарчлан болон бүлэгт сэтгэл зүйн практик асуудал (харилцаа, удирдлага)-аар зөвлөгөө өгөх			

